9	Төлөвлөгдөөгүй газар элэгдэл эвдрэлд өртөх.	Туршилт олборлолтын талбайг хашиж хамгаалан, тэмдэгжүүлэн үйл ажиллагаа явуулсан,	Туршилт олборлолтын талбай болон	Удаа	1 сая	1	Туршилт олборлолтын үед	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Зардал	Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа давтамж	Баримталсан эрх зүйн баримт бичиг
		цооногуудыг төлөвлөлтийн дагуу талбай бэлтгэн хэрэгжүүлсэн.	цооногуудын талбай					
10	Өрмийн шингэн хаягдлын сангаас хөрсөн бүрхэвчид сөргөөр нөлөөлөх.	Өрмийн шингэн хаягдлын санг стандартын дагуу байгуулах. Үл нэвчүүлэх пилонкоор доторлож битүү хашаалж хамгаалсан	Өрмийн шингэн хаягдлын сан болон туршилт олборлолтын шингэн хаягдлын сан орчим	Удаа	Үйл ажиллагааны зардал	1	Тухайн цэгт өрөмдлөг хийх хугацаанд болон туршилтын олборлолтын үед	MNS 6200:2010 Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
11	Өрмийн шингэн хаягдлын сангаас хөрсөн бүрхэвчид нөлөөлөл үзүүлэх, шимт хөрсийг стандартын бус хадгалах	Хаягдлын сан байгуулахдаа шимт хөрс болон шороон овоолгыг стандартын дагуу тусад нь тэмдэгжүүлэн хадгалж, нөхөн сэргээлтэд эргүүлэн ашигласан	Шимт хөрсны овоолго	МЗ	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	80	Өрмийн ажил эхлэхэд болон дуусахад	MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5917:2008
<b>4. Амьтан</b>								

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Зардал	Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа давтамж	Баримталсан эрх зүйн баримт бичиг
12	Амьтадын амьдрах орчинд нөлөөлөл үзүүлэх.	Жи Өү Эйч ХХК өвөджилт хүндэрсэн газруудад буюу Номгон сумын нутагт 6 цэгт 1000 ширхэг боодол өвсийг зэрлэг ан амьтанд тавьж өгч биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан	Төслийн талбай хамаарахгүй өвөлжилт хүндэрсэн нутаг байршилд	ш	5 сая	600 ш	Шаардлагатай тохиолдолд буюу цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан	Амьтны тухай хууль болон БОМТ -ийн хүрээнд

### 1.8.1 Сөрөг нөлөөллийг бууруулсан арга хэмжээний фото зургууд

Хийн алдагдал үүсэж, орчны агаарт метан хий болон бусад дагалдах хийн алдагдал үүсэхээс сэргийлж хяналтын цооногуудад алсад мэдээлэл дамжуулах төхөөрөмж суурилуулан цооногоос гарах ус болон хийн гаралтыг тогтмол хянаж байна.



Зураг 10. Шингэний болон хийн хяналт хийж буй байдал

Өрмийн үйл ажиллагааны үед ямар нэгэн осол эрсдэл үүсэхээс сэргийлж өдөр дутам заавар зөвлөмж өгөөхөөс гадна талбайн аюулгүй ажиллагааны анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажилсан.



Зураг 11. Талбайд ХАБ-ын тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байдал

Бид агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд мөн орон нутгийн удирдлага болон малчин иргэдийн санал зөвлөмжийн дагуу авто зам болон өрмийн талбай, туршилтын олборлолтын талбайг хуурайшилт ихтэй үеүүдэд услах ажлыг



хайгуулын ажлын хугацаанд зохион байгуулан ажилласан. 20т-ийн усны машинаар зам болон талбайг услаж тоосжилтыг бууруулах ажил хийгдэж буй байдлыг доорх фото зургаар үзүүлэв.



**Зураг 12. Тоосжилт бууруулах үүднээс шороон замын усалгаа хийж буй байдал**

Өмнөговь аймгийн Баян – Овоо сумын нутагт өрөмдсөн Bluebill-1S цооногийн талбайг Топ Даймонд Дрийлинг ХХК өрөмдлөг хийгдэж дууссаны талбайг усалж чийгшүүлэн тоосжилтыг бууруулж буй байдлыг доорх фото зургаар үзүүлэв.



**Зураг 13. Нөхөн сэргээсэн өрмийн талбайд усалгаа хийж буй байдал**

Өрмийн ажлын байр болон амралтын байрны цахилгаан хэрэглээг дизель генератороор шийдвэрлэсэн бөгөөд хөрсний бохирдолоос сэргийлж доор нь гялгар дэвсэж хөрсөнд тос нэвчихээс хагаалсан.




**Зураг 14. Хөрсний бохиролтоос сэргийлж генераторын доор пилонк дэвссэн байдал**

Тээврийн хэрэгслүүдээс тос, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж авто зогсоолын доор буюу машин байршуулах хэсэгт үл нэвчүүлэх пилонк дэвсэж хамгаалсан байдал.



**Зураг 15. Авто зогсоолын доор пилонк дэвссэн байдал**

Олон салаа зам үүсгэхгүй байх үүднээс нэг замын бодлого хэрэгжүүлэн ажилсан бөгөөд өрмийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө маршрут чиглэлийг нарийн төлөвлөж, газар дээр нь хяналт тавин ажилсан.



**Зураг 16. Нэг зам бодлогын хүрээнд авто замын төлөвлөлт гаргасан байдал**



**Зураг 17. Нэг замын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж буй байдал**

Төлөвлөгдөөгүй газар элэгдэл эвдрэлд өртөхөөс сэргийлж туршилтын олборлолтын зорилгоор олгогдсон талбайг бүрэн хашаажуулж тухайн талбайг зураг төсөл, төлөвлөлтийн дагуу төлөвлөн ашигласан.



**Зураг 18. Туршилтын олборлолтын талбайг хашаажуулсан байдал**



**Зураг 19. Өрмийн талбайг хашиж хамгаалсан байдал**

Өрөмдлөгийн шингэний хаягдлын сан нь өрөмдлөгийн шаврын уусмал, цооногийн угаалгын шингэн болон цооног өрөмдлөгийн үйл ажиллагааны үед үүссэн бусад холимог хаягдлыг цуглуулж хадгалах зориулалттай байгууламж бөгөөд стандартын дагуу хөрс, тухайн орчинд бохирдол үүсгэхээс сэргийлж үл нэвчүүлэх материалаар доторлож хамгаалсан.



**Зураг 20. Өрөмдлөгийн шингэний хаягдлын сан байгуулсан байдал Номгон – 10 цооног**



**Зураг 21. Хөрсөнд үзүүлэх нөлөөллийг бууруулах үүднээс үл нэвчүүлэх пилонкийг хогийн цэгийн доор дэвссэн байдал**

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт зуншлага тааруу болсон өвөлжилт хүндэрсэн газруудад орон нутгийн иргэдтэй хамтран 6 цэгт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж 600 ш боодол өвсийг тараан байршуулсан. Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж буй байдлыг доорх фото зургаар үзүүлэв.



**Зураг 22. Биотехникийн арга хэмжээний өвс зөөж буй байдал**

Ууланд биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлж өвс тараан байршуулж буй байдлыг доорх фото зургаар үзүүлэв.



**Зураг 23. Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлж буй байдал**

## 1.9 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Номгон IX” талбайд 2023 оны хайгуулын ажлын төлөвлөгөөнд 2D буюу 2 хэмжээст чичирхийллийн судалгаа болон малталтын судалгааны ажил төлөвлөгдөөгүй учир цооногуудын нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдсөн байна. Төлөвлөгөөнд нийт 9-10 цооног өрөмдөх төлөвлөгөөтэй байсан боловч зарим нэгэн шалтгаан өрөмдлөгийн ажлын хүндрэл гүйцэтгэл зэргээс хамааран 2023 онд 7 цооног өрөмдсөн байна. Уг долоон цооногийн нөхөн сэргээлтийг “Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” техникийн ерөнхий шаардлага MNS 6200:2010 стандартын дагуу нөхөн сэргээлт хийн сум орон нутагт зохих журмын дагуу талбайг хүлээлгэн өгсөн байна. Цооногуудын талбайд нөхөн сэргээлт хийн орон нутагт хүлээлгэн өгсөн актыг хавсралт ...-д үзүүлэв.

### Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Зардал	Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хайгуулын цооногийн нөхөн сэргээлт хийх	2023 онд хийгдсэн хайгуулын болон үнэлгээний 7 цооногийн нөхөн сэргээлтийг “Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” техникийн ерөнхий шаардлага MNS 6200:2010 стандартын дагуу нөхөн сэргээлт хийн сум орон нутагт зохих журмын дагуу талбайг хүлээлгэн өгсөн	2023 онд өрөмдлөг хийсэн цооногууд	га	18 сая	7 цооногийн ойролцоогоор 2.5 га	Тухайн жилийн цооногуудыг өрөмдөж дууссаны дараа	“Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” техникийн ерөнхий шаардлага MNS 6200:2010

2	Туршилт олборлолтын талбайд хийгдсэн цооногийн нөхөн сэргээлт хийх	Туршилт олборлолтын талбайд үйл ажиллагаа явагдаж буй учир нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй харин талбайд хийгдсэн Номгон 10 цооногийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага болох Баянтал Энержи ХХК-иар гүйцэтгүүлсэн.	Номгон 10 цооногт	га	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	Ойролцоогоор 0.3 га	Тухайн цооногийн хүрээнд нэг удаа	MNS 6200:2010 MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5917:2008
3	Ногоон байгууламж нэмэгдүүлэх, мод тарих	Жи Өү Эйч ХХК нь “Тэмбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Номгон суманд 5 га талбайд хамгаалалтын ногоон зурвас байгуулах ажлыг 2 жилийн өмнө эхлүүлэн ажиллаж байна. 2023 онд 2113 мод тарихаар төлөвлөсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлэн ажилсан. Намрын тооллогоор 93% ургалттай байсан. Мөн 10000 хайлуусны суулгац үржүүлсэн. 11 сард 40кг загийн үрийн нөөц бий болгосон.	Жи Өү Эйч ХХК нь “Тэмбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд байгуулсан 5 га талбайд	ш	11.6 сая төг	2000 ш	Жил бүр хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд жил бүр тарих модны хэмжээ өөр байх боломжтой.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
4	Суулгацыг арчлан тордох	Ногоон байгууламжийг арчилж хамгаалах ажлыг орон нутгийн Хаан түшиг мандал ХХК хариуцан ажиллаж байна.		-	Ү/А-ны зардалд тусгагдсан	-	Өдөр дутам	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Мод тарих, арчилж хамгаалах



								агротехникийн аргачлал
5	Усалгаанд шаардлагатай хэрэгслийг бэлтгэх (Усны нөөцийн сав 10 тн , зарим усалгаанд шаардлагатай шланк крантууд )	Шаардлагатай хэрэгсэл тоног төхөөрөмж, усалгааны багаж хэрэгслээр бүрэн хангасан.	Мод үржүүлгийн 5 га талбайд	-	Ү/А-ны зардалд тусгагдсан	-	-	Хамтран ажиллах гэрээний дагуу

Жи Өү Эйч ХХК -ийн Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” санаачлагын хүрээнд хэрэгжүүлж буй ногоон төгөл болон мод үржүүлгийн талбай.



Зураг 24. Жи Өү Эйч ХХК -ийн ногоон төглийн талбай




Зураг 25. Модны усалгаа хийж буй байдал

Хайлаасыг хүлэмжинд үржүүлж буй байдал, 2023 онд 10000 ширхэг хайлаасыг үрээр үржүүлээд байна. Тухайн үржүүлсэн хайлаасыг жилд тодорхой хэмжээтэйгээр төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гадна талбайд гаргаж тарьж ургуулахаар төлөвлөн ажиллаж байна.



**Зураг 26. Мод үржүүлэх зорилгоор 2 хүлэмж байгуулсан.**



**Зураг 27. Мод үржүүлгийн талбайд хүлэмж байгуулсан байдал**

## 1.10 Цооногуудын нөхөн сэргээлт хэрэгжүүлсэн байдал

Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Номгон – IX талбайн 2023 оны хайгуулын ажлын хүрээнд нийт 7 цооног буюу хайгуулын 3, үнэлгээний 4 цооног өрөмдөх ажил хийгдсэн. Эдгээр 7 цооногийн хувьд Топ Даймонд Дриллинг ХХК хайгуулын 1 цооног, Мэйжор Дриллинг Монгол ХХК үнэлгээний 2 цооног, Эрдэнэ дрийлинг ХХК хайгуулын 2, үнэлгээний 2 нийт 4 цооног тус тус өрөмдсөн бөгөөд эдгээр 3 компани цооногийн нөхөн сэргээлтийн ажлаа бүрэн хариуцан ажилсан. Цооногуудын талбайг нөхөн сэргээх ажлыг “Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 6200:2010 стандартын болон “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008 стандарт, БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”, зэргийг мөрдлөг болгон хийж гүйцэтгэсэн

Номгон – IX талбайд 2023 онд өрөмдлөг хийсэн цооногуудын нэр, төрөл, гүн, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг доорх хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 5. Цооногийн товч мэдээлэл болон нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ**

№	Цооногийн нэр	Цооногийн төрөл	Бодит гүн,м	Нөхөн сэргээсэн талбай /га/	Гүйцэтгэгч компани
1	Bluebill-1S	Хайгуулын	549	0.1	“Топ Даймонд Дриллинг” ХХК
2	Big Slope-7	Үнэлгээ	665.7	0.6	“Эрдэнэ дрийлинг” ХХК
3	Big Slope-Shallow-1	Үнэлгээ	620.5	0.6	“Эрдэнэ дрийлинг” ХХК
4	Big Slope West-1S	Хайгуул	320.6	0.5	“Эрдэнэ дрийлинг” ХХК
5	Yangir West-2	Үнэлгээ	519.4	0.2	Мэйжор Дриллинг Монгол ХХК
6	Yangir Far West-1	Хайгуул	506	0.5	“Эрдэнэ дрийлинг” ХХК
7	Nomgon-10	Үнэлгээ	472	0.03	Мэйжор Дриллинг Монгол ХХК

**Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил:** Цооногуудын нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил нь тухайн цооногийг өрөмдөж эхлэхээс өмнө хийгдэж эхэлдэг бөгөөд цооногийг өрөмдөхөөс өмнө талбайтай танилцаж ерөнхийд нь төлөвлөх, ямар хэмжээний талбайд өрмийн үйл ажиллагаа явуулах, өрмийн гүн, төрлөөс хамааруулан өрмийн шингэн хуримтлуулах сан байгуулах талбай бэлдэх, нөлөөлөлд өртөх талбайн шимт хөрсийг стандартын дагуу хуулж “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008 стандартын

дагуу хуулж хадгалсан бөгөөд техникийн нөхөн сэргээлт хийхдээ нөлөөлөлд өртсөн талбайг хуулсан шимт хөрсөөрөө хучиж ашигласан.

Өрөмдлөгийн ажил хийгдэж дууссаны дараа техникийн нөхөн сэргээлтэд бэлтгэж өрмийн үйл ажиллагаанд ашиглагдсан багаж техник тоног төхөөрөмжүүдийг буулгах, хамгаалалтын хашааг хураах талбайг чөлөөлөх ажлууд хийгдсэн бөгөөд талбай чөлөөлөх ажил хийгдэж дууссаны дараа талбайг цэвэрлэх, хог хаягдал бохирдлыг цэвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлсэн.



**Зураг 28. Нөхөн сэргээлтийн үеийн цэвэрлэгээ хийгдэж буй байдал**

#### **1.10.1 Цооногийн битүүмжлэл**


Газрын тосны хайгуул, ашиглалтын цооногийг цаашид өөр зориулалтаар ашиглахгүй нөхцөлд цооногийг төмөр-бетон хийц ашиглан битүүмжилж, амсрын бэхэлгээний янданг газрын гадаргуутай тэгш түвшинд тайрч, төмрөөр таглаж гагнах ба таган дээр цооногийн нэр, дугаар, хаасан огноог бичиж тэмдэглэнэ гэж стандартад заагдсаг байдаг учир цооногийн битүүмжлэлийг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Цооногийн битүүмжлэлийг доорх фото зургаар үзүүлэв.



**Зураг 29. Bluebill-1S(Re) хайгуулын цооногийг битүүмжилсэн байдал**



**Зураг 30. Big Slope-7 үнэлгээний цооногийг битүүмжилсэн байдал**



**Зураг 31. Big Slope Shallow-1 үнэлгээний цооногийг битүүмжилсэн байдал**



**Зураг 32. Big Slope West-1S, хайгуулын цооногийг битүүмжилсэн байдал**



**Зураг 33. Yangir Far West-1S, хайгуулын цооногийг битүүмжилсэн байдал**



**Зураг 34. Yangir West-2, үнэлгээний цооногийг битүүмжилсэн байдал**

**Нөхөн сэргээлтэнд ашигласан техник, тоног төхөөрөмж:** Уламжлалт бус газрын тосны хайгуулын болон үнэлгээний цооногуудын өрөмдлөгийн ажил нь

маш бага талбайд явагддаг, газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага байдаг учир нөхөн сэргээлтэнд олон тооны хүнд даацын том машин техник харьцангуй бага шаардагддаг. Нөхөн сэргээлтэнд ашиглагдсан машин техникийн жагсаалтыг доорх хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн ажилд ашигласан машин механизм**

№	Машины нэрс	Марк	Зориулалт
1	Экскеватор	HYUNDAI 2900LC	Газар ухах
2	Авто ачигч	SDLG маркын LG953	Шороо ачих, газар тэгшлэх.
3	Авто чирэгч	NORT BENZ	Хүнд механизм ачиж тээвэрлэх
4	Ачааны машин	HINO 7960cc	Ачаа ачих

Нөхөн сэргээлтийн ажилд доорх багаж хэрэгслүүдийг ашиглав.


- Хүрз
- Лоом
- Ажлын бээлий
- Тармуур
- Хамгаалалтын тууз, анхааруулах тэмдэг
- Метр
- Төмөр утас
- Бахь
- Хамгаалалтын хувцас хэрэглэлүүд

**1.10.2 Bluebill-1S цооногийн нөхөн сэргээлт**

“Топ даймонд дрийлинг” ХХК нь Номгон – IX хайгуулын талбайд буюу Өмнөговь аймгийн Баян – Овоо сумын Налих багий нутагт хайгуулын зориулалттай Bluebill-1S цооногийг өрөмдсөн бөгөөд өрмийн ажлыг 2023 оны 6 сарын 10 -аас 7 сарын 28 ны хооронд 549 м гүн өрөмдлөг гүйцэтгэсэн байна. Тухайн өрөмдлөгийн үйл ажиллагаанаас 0.1 га талбай нөлөөлөлд өртсөн бөгөөд тухайн нөлөөлөлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийг зохих стандарт, шаардлагын дагуу хийж гүйцэтгэн 2023 оны 8 сарын 18 нд орон нутагт хүлээлгэн өгсөн бөгөөд талбайг зохих журамын дагуу акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна. Талбайд нөхөн сэргээлт хийн орон нутагт хүлээлгэн өгсөн актыг хавсралт ...-д үзүүлэв.

Bluebill-1S цооногийн техникийн нөхөн сэргээлт хийсний дараах төрх байдлыг доорх фото зургаар үзүүлэв.





**Зураг 35. Bluebill-1S цооногийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал**

### **1.10.3 “Эрдэнэ дрийлинг” ХХК -ийн хийсэн 4 цооногийн нөхөн сэргээлт**

“Эрдэнэ дрийлинг” ХХК Өмнөговь аймгийн Номгон сумын Эмгэн булаг багийн нутагт Big Slope-7, Big Slope-Shallow-1, Big Slope West-1, Yangir Far West-1 гэсэн 4 цооног өрөмдсөний бөгөөд уг цооногуудыг 2023 оны 7 сарын 7 -оос 9 сарын 28 ны хооронд 320-667 м гүнтэй өрөмдлөгүүдийг хийж гүйцэтгэсэн байна. Уг өрөмдлөгийн үйл ажиллагааны улмаас цооног бүрд 0.3 – 0.5 га буюу нийт 2 га талбайн нөлөөлөлд өртсөн байна. Уг нөлөөлөлд өртсөн талбайдад техникийн нөхөн сэргээлтийг зохих стандарт, шаардлагын дагуу хийж гүйцэтгэн сум орон нутагт зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн байна. “Эрдэнэ дрийлинг” ХХК ийн өрөмдсөн цооногуудын нөхөн сэргээлтүүдийг доорх фото зургуудаар үзүүлэв.



**Зураг 36. Big Slope-7 цооногт нөхөн сэргээлт хийсэн байдал**



**Зураг 37. Big Slope West-1 цооногт нөхөн сэргээлт хийсэн байдал**



**Зураг 38. Big Slope-Shallow-1 цооногийн талбайн нөхөн сэргээсэн байдал**



**Зураг 39. Yangir Far West-1 цооногийн талбайг нөхөн сэргээсэн байдал**

#### **1.10.4 Мэйжор Дриллинг Монгол ХХК -ийн хийсэн 2 цооногийн нөхөн сэргээлт**

“Мэйжор Дриллинг Монгол” ХХК нь Өмнөговь аймгийн Номгон сумын Эмгэн булаг багийн нутагт Задгайтын эхэнд Yangir West-2 нэртэй 1 цооног, мөн эмгэн булаг багийн нутаг Цагаан толгой бүтцийн ородод Номгон – 10 нэртэй 1 цооног нийт 2 цооногт өрөмдлөг гүйцэтгэсэн байна. Уг цооногуудыг “Мэйжор Дриллинг Монгол” ХХК нь 2023 оны 8 сарын 27 -оос 9 сарын 23 ны хооронд 472-519 м гүнтэй өрөмдлөгүүдийг хийж гүйцэтгэсэн байна.

Уг өрөмдлөгийн үйл ажиллагааны улмаас Yangir West-2 цооног орчим 0.2 га, Номгон-10 цооног орчимд буюу нийт 0.03 га талбайн тус тус нөлөөлөлд өртсөн байна. Уг нөлөөлөлд өртсөн талбайдад техникийн нөхөн сэргээлтийг зохих стандарт, шаардлагын дагуу хийж гүйцэтгэн сум орон нутагт зохих журмын дагуу хүлээлгэн өгсөн байна. “Мэйжор Дриллинг Монгол” ХХК -ийн өрөмдсөн цооногуудын нөхөн сэргээлтүүдийг доор авч үзэв. Орон нутагт талбай хүлээлгэн өгсөн актыг хавсралт 4- үзүүлэв.



**Зураг 40. Yangir West-2 цооногт нөхөн сэргээлт хийж байх үеийн фото зураг**



**Зураг 41. Yangir West-2 цооногт нөхөн сэргээлт хийсний дараах фото зураг**

#### **1.10.5 Номгон-10 цооногийн нөхөн сэргээлт**

“Номгон – 10” үнэлгээний цооног нь туршилт олборлолтын талбайд хийгдсэн учир тухайн цооногийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн нөхөн сэргээлтийн компаниар гүйцэтгүүлсэн. Өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн “Мэйжор Дриллинг Монгол” ХХК нь уг нөхөн сэргээлтийн ажлын нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөл бүхий “Баянтал Энержи” ХХК -иар гүйцэтгүүлсэн байна.

**Нөхөн сэргээлтийн ажиллах хүч:** “Номгон – 10” үнэлгээний цооногийн шингэн хаягдлын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд төслийн багийг “Баянтал Энержи” ХХК-ийн бодлого журмын дагуу бүрдүүлэн 4 албан тушаалд 4 хүний бүрэлдэхүүнтэй 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд ажиллуулсан болно.

Ажлын талбайд ажиллах цагийн хуваарь нь 8 цаг бөгөөд бүх ажилчид 1 ээлжээр ажилласан ба ажилчдад өдөр тутмын ажлын үүрэг болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилтан тус бүрт ХАБ-ын багж хэрэгсэлээр ханган ажилласан болно.

### Хүснэгт 7. Баянтал Энержи ХХК -ийн нөхөн сэргээлтийн талбайд ажилласан ажилчид

№	Ажилтны овог нэр	Албан тушаал
1	Ц.Батхүү	Төслийн менежер
2	Б.Гансүх	Талбайн менежер
3	С.Батсүх	Оператор
4	П.Ган-Эрдэнэ	Жолооч, туслах

**Төслийн менежер:** Төслийн үйл ажиллагааг төлөвлөх, үнэлэх замаар төслийн зорилго зорилтыг хэрэгжүүлэх, холбогдох хууль, дүрэм журам, стандартуудыг мөрдөж ажиллах, ажилчдыг удирдан чиглүүлэх, зааварлах, сургах, ажилд томилох, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж явцын мэдээ болон гүйцэтгэлийн тайлан гаргаж компанийн удирдлагад болон захиалагч талд, мөн орон нутгийн мэргэжлийн байгууллагын ажлын хэсэгт тайлагнах

**Талбайн менежер:** Төслийн үйл ажиллагааны явцад шаардагдах санхүүгийн бүх зардлыг тооцон захиран зарцуулах, худалдан авалт хийх, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг ханган тайлагнах, ажилчдыг амрах ажиллах нөхцлөөр хангах, шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хагнах.

**Оператор жолооч:** Нөхөн сэргээлтийн талбай болон сум, хот хоорондын ачаа тээвэр хийх, хариуцаж буй машины бүрэн бүтэн байдлыг хангах, төслийн талбайд хүнд механизм / экскеватор, ковш /ажиллуулах үедээ техникийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, ажил эхлэх болон дуусах үед тойрох үзлэгийг тогтмол хийх.

**Туслах ажилтанх:** Удирдах ажилтны заавар зөвлөгөөгөөр өдөр тутмын ажилд гар бие оролцох, бараа материал ачиж буулгах.

**Химийн бодисын зарцуулалт, худалдан авалт:** Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ашигт Малтмал, Газрын Тосны газраас гаргасан “Өрмийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлтийн зөвлөмж”-д Хөнгөнцагааны сульфат /  $Al_2(SO_4)_3$  / болон Хлорт магни /  $MgCl_2$  / бодисуудыг нэг шингэн хаягдлын санд стандартын дагуу 300 кг-1200кг хүртэл хийж хутгах зааврын дагуу энэхүү хоёр төрлийн химийн бодисуудыг гадаад улсаас химийн бодис оруулж ирж худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй “Ундрах гарц”ХХК-иас худалдан авсан.

Дээрхи хоёр төрлийн химийн бодисыг ашиглахдаа хаягдлын сан тус бүрт нь өөр өөр хэмжээтэй хийсэн тул доорхи хүснэгтээр тодорхой үзүүлэв.

### Хүснэгт 8. Нөхөн сэргээсэн хаягдлын санд зарцуулсан химийн бодисын хэмжээ

№	Хаягдлын сангийн нэр	Гүн (м)	Талбай	Бодис хийн хутгасан сар, өдөр		Зарцуулсан химийн бодисын хэмжээ (кг)		Хаягдлын санг булсан сар, өдөр
				Al <sub>2</sub> (SO <sub>4</sub> ) <sub>3</sub>	MgCl <sub>2</sub> *6H <sub>2</sub> O	Al <sub>2</sub> (SO <sub>4</sub> ) <sub>3</sub>	MgCl <sub>2</sub> *6H <sub>2</sub> O	
1	Өрмийн шингэн хаягдлын сан	3.5	144 м <sup>2</sup>	2023 10.16	2023 10.18	500	500	2023.10.24
<b>Нийт</b>						<b>1000</b>		

**Хүснэгт 9. Химийн бодисын нэршил, хэмжээ**

№	Химийн бодисын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт хэмжээ (кг)
1	Нэр: Хөнгөнцагааны Сульфат Al <sub>2</sub> (SO <sub>4</sub> ) <sub>3</sub> Үйлдвэрлэгч: ОХУ Хэмжээ: 25кг	Шуудай	20	500
2	Нэр: Хлорт магни MgCl <sub>2</sub> *H <sub>2</sub> O Үйлдвэрлэгч: ОХУ Хэмжээ: 25кг	Шуудай	20	500
<b>Нийт</b>			<b>40 ш</b>	<b>1000 кг</b>

**ХАБЭАБО-ны үйл ажиллагаа:** Нөхөн сэргээлтийн ажилд ашиглаж буй техник тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийн “Эрсдэлийн үнэлгээ”-г боловсруулан ажилласан.

**Хүснэгт 10. Эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал**

№	Ажлын талбарын тодорхойлолт	Аюулын төрөл	Аюулын тодорхойлолт/ дэд төрөл/	Үр дагавар	Тохиолдох магадлал	Эрсдэлийн үнэлгээ
1	Номгон – 10 цооногийн Өрмийн Шингэн хаягдлын сан нөхөн сэргээлтийн талбай	Биологийн	Шавьж хорхой /аалз/	1-Хөнгөн	С - Болзошгүй	Бага
2		Цаг агаар / Байгалийн үзэгдэл	Шороон шуурга болон хүйтэн бороо	1 - Хөнгөн	В - Өндөр	Дунд
3		Ажлын байрны зохион байгуулалт	Нэг хэвийн давтагдах хөдөлгөөн	- Хөнгөн	С - Болзошгүй	Бага
4		Хүндийн хүч	Өндрөөс унах	3 - Ноцтой	D - Бага	Бага
5		Хүндийн хүч	Гадны биет дээр унах, бүдрэх, хальтрах	3 - Ноцтой	В - Өндөр	Дунд
6		Нийгэм / соёлын	Лицензийн /хэрэглэх эрх/ шаардлага	2 – Дунд зэрэг	D – Бага	Бага
7		Шатамхай бодис /шатамхай шингэн ба	Тос тослох материал	1 - Хөнгөн	С - Болзошгүй	Бага

		хатуу бодис				
8		Дулаан /Гал / Тэсрэх бодис	Хүйтний стреес	1 – Хөнгөн	C - болзошгүй	Бага
9		Тээврийн хэрэгсэл /зам тээвэр	Том оврын ачааны болон суудлын тэрэг	4–Онц ноцтой	D - Бага	Их

**Номгон – 10 цооногийн техникийн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл:**

Техникийн нөхөн сэргээлтийн ажил нь 10 дугаар сарын 16-ны өдөр эхэлсэн бөгөөд тухайн өдөр шингэн хаягдлын сангийн гадна талын торон хашааг буулган нөхөн сэргээлт хийх талбайгаас холдуулан өөр байршилд хурааж байрлуулсан. Мөн шингэн хаягдлын санд хэмжилт хийсэн. Энэхүү хэмжилтээр сангийн лаг шаврын зузаан нь 1м, усны түвшин нь 2.5м байсан.



**Зураг 42. Номгон-10 цооногийн өрмийн шингэн хаягдлын сан нөхөн сэргээхийн өмнө**

Дээрхи ажил хийгдэж дууссаны дараа төлөвлөлтийн дагуу энхий бодис болох Хөнгөнцагааны сульфат ( $Al_2(SO_4)_3$ )-ыг 1 санд 500кг-ыг хийж хутган саармагжуулах ажил хийсэн. Ингэснээр хөнгөнцагааны сульфат нь устай урвалд орж хүчиллэг шинж чанартай болж, сангийн шингэн нь саармаг шинж чанартай болон Ph-ийг тэнцвэржүүлэн  $SO_4$  нь хүнд металлын полимертой нэгдэж, уусдаггүй идэвхгүй сульфат болон хувирч, хорт шинж чанарыг арилган хоргүйжүүлэлт хийсэн.





**Зураг 43. Бэхсжүүлэх бодис хольж байх үеийн фото зураг**

Дараагийн Хлорт магни ( $MgCl_2 \cdot nH_2O$ ) бодисыг 10 дугаар сарын 18-ны өдөр санд хийж хутгасан ба санд 500кг-ыг хийж эксковаторын шанагаар хутгалт явуулан 10 дугаар сарын 23-ын өдөр хүртэл бэхжүүлэлтийн ажил хийсэн. Хлорт магни нь ус шингээх чанар өндөр, мөн электролит шинж чанар өндөр тул шавар болон хаягдал шингэний усны агууламжийг багасгаж өгдөг. Мөн бүхэл биет болон хувирч органик болон хүнд металлын полимеруудтай нэгдэсний дараа шороо нэмж хутгаснаар бэхжинэ. Энэ удаагийн техникийн нөхөн сэргээлтийг намар орой болсон буюу харьцангуй сэрүүн нөхцөлд хийгдсэн, мөн шингэн хаягдал 80% усархаг төлөвтэй зэргээс хамааран бэхжилт нь удаашралтай байсан тул нөхөн сэргээж буй сангийн дэргэд овоолго шороо байрлуулан саарал усыг нь соруулан авч тогоолон уусгах маягаар шороотой зуурч өтгөрүүлэн сандаа буцааж хийх хэлбэрээр бэхжилтыг нь хурдасган ажилласан.



**Зураг 44. Бэхжүүлэлт хийгдэж байх үеийн фото зураг**

Тухайн хаягдлын санг булж тэгшлэхдээ холбогдох стандартын журамын дагуу дотор талын дүүргэлт хийсэн хэсгийг шингэн үл нэвчуулэх материалаар өлгийдөх хэлбэрээр хучиж, дээгүүр нь шороо асган тэгшилж нягтаршуулсан. Үүний дараа хаягдлын сангийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хөрсийг 0.07МПа (1.0м2 талбайд 7.0тн жингээр дарах хүч)-аас багагүй даралтыг даах хэмжээнд хүртэл нягтруулан, 1,2м –ээс илүүгүй өндөртэйгээр хөрсний суултыг тооцон, 17-18 радиусын налуутай овоолго үүсгэсэн.



Зураг 45. Номгон – 10 цооногийн талбайд нөхөн сэргээлт хийж буй байдал

#### 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагааны шатанд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй тул төлөвлөөгүй болно.

#### 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Номгон IX талбайн 2023 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн цооног өрөмдлөгийн үйл ажиллагаанд өртөх нутгийн малчин айл өрхийн өвөлжөө, хаваржаа, суурин газар байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагагүй тул 2023 оны БОМТ-нд төлөвлөөгүй болно.

## **6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Жи Өү Эйч” ХХК нь БХГ-т “Номгон-IX” талбайдаа Соёлын өвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10-т заасны дагуу 2018 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээр Угсаатны зүй, соёлын нөлөөллийн үнэлгээний судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн бөгөөд тус судалгаанд хамрагдсан дурсгалууд нь 2023 оны хайгуул судалгааны үйл ажиллагаанд өртөхөөргүй байна. Харин цооног өрөмдлөгийн судалгаа, суваг байгуулах зэрэг газар шорооны ажлын үед газрын хөрсөн доор мэдэгдээгүй үлдсэн соёлын биет өв илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасан.

Төсөл хэрэгжүүлэгч нь мэргэжлийн байгууллагаар Археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгааг Номгон-IX хайгуулын талбайн хэмжээнд хийлгүүлсэн байна. Тухайн судалгааны дүгнэлтийг хавсралт .... -д үзүүлэв.

“Номгон-IX” талбайн өрөмдлөгийг үйл ажиллагааны үед түүх соёлын өвтэй холбоотой ямар нэгэн биет өв илрээгүй учир ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй болно.

### **1.11 Археологийн судалгаа**

Төсөл хэрэгжүүлэгч нь хайгуулын үйл ажиллагаа эхлэхийн өмнө 2018 оны 11 сард ШУА-ын Түүх, Археологийн хүрээлэнгийн судлаачдын багаар Номгон-IX хайгуулын талбайн хэмжээнд Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг хийлгэсэн байна.

ШУА-ын Түүх, Археологийн хүрээлэнгийн 2018 оны 11 сарын 14 өдрийн 2/596 тоот судалгааны дүгнэлтэд 1-р шугамын урд хэсэгт 3, дунд хэсэгт 4, хойд хэсэгт 1 дурсгал, 3-р шугамын урд хэсэгт 2, дунд хэсэгт 4 дурсгал, 4-р шугамын хойд хэсэгт 4 дурсгал, 5-р шугамын урд хэсэгт нэг дор 6 дурсгал тус тус бүртгэгдсэн байна. эдгээрт шоргоолжин булш 1, дөрвөлжин булш 1, хадны зураг 1, хүннү булш 6, монгол булш 5, он цаг тодорхойгүй 9 булш, 1 чулуун байгууламж байна. Энэхүү археологийн дурсгалууд нь 2019, 2020, 2021, 2022 оны чичирхийллийн хайгуулын шугам болон цооног өрөмдлөгийн үйл ажиллагаанаас зайтай байрлах тул сөрөг нөлөөлөл үүсээгүй. Цаашид эдгээр дурсгалуудын хадгалалт хамгаалалтын байдалд анхаарч, үйл ажиллагаанд өртөж, хөндөгдөх тохиолдолд мэргэжлийн байгууллагаар малтан судлуулж, чөлөөлүүлэх шаардлагатай. Мөн суваг байгуулах газар шорооны ажил, цооног өрөмдлөгийн үед газрын хөрсөн доор булшлагдсан дурсгал байхыг үгүйсгэхгүй тул Соёлын өвийг хамгаалах тухай

хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” заалтыг хэрэгжүүлэн ажиллана.


### **1.12 Палеонтологийн судалгаа**

“Жи Өү Эйч” ХХК-ий хүсэлтээр Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн (ШУА) Палеонтологи, геологийн хүрээлэн (ПГХ)-ээс нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Номгон-IX талбайн хэмжээнд тархсан палеонтологийн үйлдвэр, тэдгээрийг агуулагч хурдсын судалгааг 2018 онд гүйцэтгэсэн байна.

Уг судалгаагаар хайгуулын талбайн 95 орчим хувь нь силурээс неоген хүртэлх насны тунамал хурдсуудаас бүрдэнэ. Хэдийгээр тус хайгуулын ажлаар талбайд тархсан бүх хурдсаас эртний амьтан, ургамлын үлдвэр ажиглагдаагүй ч цаашдын үйл ажиллагааны явцад илрэх магадлал өндөр гэсэн байна. Учир нь тус талбайд өмнөх геологийн зураглал болон палеонтологийн судалгааны явцад эртний организмын үлдвэр илэрч байсан хурдсууд ихээр тархжээ. Талбайн өмнөд хэсэгт тархах дээд цэрдийн Баянширээ формац нь 50 м орчим зузаантай ба цавууд үүсгэн тогтдог ба үлэг гүрвэлийн үлдвэр олдоогүй. Номгон-IX талбайд тархах ихэнх тунамал зузаалгууд нь эртний организмын үлдвэр агуулдаг ч тус хайгуулын ажлын явцад олдворын тархац багатай зарим хурдсаас огт ажиглагдаагүй байна.

Судалгаагаар Номгон-IX хайгуулын талбайн хэмжээнд 60 орчим цэгт малтлага, ажиглалт судалгааг хийж, 2 байршилд эртний модлог ургамлын үлдвэр (Номгон сумын нутагт, зүүн хойд талд) болон хөхтний шүд, хавирга болон гавлын хэсгүүд (Ханхонгор сумын нутаг, баруун хойд талд) олдсон байна. Олдвор олдсон байршлыг доорх зурагт харуулав.

Доорх зургаас харахад палеонтологийн олдворын байршилтай 2023 оны хайгуулын өрөмдлөгийн цэгүүд давхцахааргүй байна.



Зураг 46. Палеонтологийн олдворын байршил

### 1.13 Угсаатны зүйн судалгаа

Төсөл хэрэгжүүлэгч “Жи Өү Эйч” ХХК ШУА-ын Түүх, Археологийн хүрээлэнгийн судлаачдын багаар 2018 онд БХГ-т Номгон-IX талбайн хэмжээнд Угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлыг хийлгэсэн байна.

Угсаатны зүйн хээрийн судалгааны үндсэн чиглэлээс хамаарч доор дурдсан байдлаар ангилж үзсэн байна. Үүнд:

1. Хорио цээрт газар орон
2. Тахилга, шүтлэгт орон
3. Малчдын бууц суурин гэсэн үндсэн агуулгад хамруулан авч үзжээ.

Энэхүү судалгаагаар нийт 41 угсаатны зүй, соёлын өв бүртгэгдсэн байна. Үүнд 23 тооны малчдын өвөлжөө, хаваржааны бууц, овоо тахилгат газар 8, уст цэг 1, Зүүн хайрхан, Булган толгой зэрэг тахилгат уул, Эртний суурин, Лүнгийн хийдийн туурь болон Тугийн цохио зэрэг түүхийн дурсгалт газар бүртгэгджээ.

2023 оны хайгуул судалгаа болон туршилтын талбайн цооног өрөмдлөгийн үйл ажиллагаанд дээрх угсаатны зүйн судалгаанд тэмдэглэгдсэн соёлын өвийн дурсгал өртөөгүй болно.

## **7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хайгуулын ажлын хүрээнд 2023 онд осол эрсдэлээс урьдчилан сэргийлж дараах ажлуудыг хийсэн .Уг ажлууд нь мөн адил өмнөх онуудад хийж гүйцэтгэж байсан байсан харьцангуй тогтворжсон үйл ажиллагаа юм. Үүнд:

Төлөвлөгөөний хүрээнд ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах, өдөр бүр нийт ажилчдад Аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, ажлын байрны сургалтууд зохион байгуулах, заавар зөвлөмж боловсруулан танилцуулах, ажлын байрны шат дараалсан үзлэг хийж аюул эрсдэлийг арилгах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Кэмпд шаардлагатай галын цэг, угаалгын усны нүх, хуурай хог хаях цэг, нойтон хаях цэгүүдийг хийж тэмдэг тэмдэглэгээ хашилтыг байршуулж тавьсан.
- ГАБ-ийг хангах зорилгоор ажлын байр, гал тогоо, амралтын байрнуудад галын хорнууд болон галын анхан шатны багаж хэрэгслүүдийг байрлуулж тэдгээрийн ажиллагаа болон бэлэн байдлыг тогтмол шалган хяналт тавьж ажилласан.
- Мөн шинээр ирж байгаа ажилчдад аюулгүй ажиллагаа, Галын аюулгүй байдлын галын хорыг хэрхэн ажиллуулах, өндөр эрсдэлтэй ажлын байрнуудын талаар сургалт байнга хийгддэг
- Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох сургалт болон галын аюулгүй байдлыг хангах зорилгоор төлөвлөөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.
- Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын байр болон амралтын байруудад галын хорыг байрлуулан тухай бүрт нь үзлэг шалгалтыг хийж ажилласан байна.

**Хүснэгт 11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журам зөрчигдэх	Хайгуулын ажил эхлэхийн өмнө төсөл хэрэгжүүлэгч гүйцэтгэгч байгууллагуудтай уулзаж ХАБ-ын талаар заавар зөвлөмж өгч хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэгдүгээр тавин ажиллах, монгол улсад мөрдөгдөж буй дүрэм журмын хүрээнд ажиллах зөвлөмж өгсөн.	ХАБЭА	Төслийн талбайд бүх ажилчид гэрээт байгууллагууд	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлсэн	Хээрийн ажилд гарахын өмнө болон төслийн талбайд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17.1, 17.3, 28.1.7
2	Галын аюулгүй байдлын дүрэм журам зөрчигдөх	Галын аюулгүй байдлын дүрэм журамыг гэрээт байгууллагууд боловсруулан мөрдлөг болгон ажилсан. Төсөл хэрэгжүүлэгч болон геологич нар өдөр дутам хяналт тавин ажилсан.	Галын аюулгүй байдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлсэн	Хээрийн ажилд гарахын өмнө болон төслийн талбайд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 13.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7.1, 17.2.4
3	Ажилчид гэнэтийн осолд өртөх	Хөдөлмөрийн аюулгүй байдлын заавар зөвлөмжийг ажилд гарахын байнга өгч ажилсан бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажилсан.	Ажилчдын эрүүл мэнд	Тогтмол	ХАБЭА-н зардал	Өрөмдлөг болон үйл ажиллагааны үед	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.7, 28.1.16
	Болзошгүй осол аваар гарах	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, осол эрсдлээс сэргийлэх санамж, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Өрөмдлөгийн талбай болон туршилт	Тогтмол	ХАБЭА-н зардал	Өрөмдлөг болон үйл ажиллагааны үед	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн



			олборлолтын талбайд				тухай хуулийн 28.1.1, MNS 4643 :1998 MNS 12.4.002:2020
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл алдагдах	Хээрийн ажлын шатанд ослыг судлан бүртгэж, залруулах арга хэмжээг авах, сэрэмжлүүлэг мэдээллийг самбарт байрлуулан ажилтнуудад зааварчилгаа өгч ажилласан	Ажлын талбар дах болзошгүй осол	Тогтмол	ХАБЭА-н зардал	Тухай бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.11, 28.1.13
6		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Бүх ажилчид	тогтмол	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны явцад	-
7	Хээрийн ажлын шатанд шаардлагатай байршлуудад галын аюулаас хамгаалах хэрэгслүүдийг байршуулах	Хээрийн ажлын шатанд шаардлагатай байршлуудад галын аюулаас хамгаалах хэрэгслүүдийг байршуулан ажилсан.	Галын аюулгүй байдал	7 ш	Үйл ажиллагааны зардал	Талбайн бэлтгэл ажлын үед	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйл
8	Өрмийн ажил дууссаны дараа хаягдлын санд нөхөн сэргээлт хийгээгүй байх үед мал, хээрийн амьтад хаягдлын санд унах	Шингэн хаягдлын санд стандартын дагуу торон хашаа татаж тухай эрсдэл үүсэхээс сэргийлж ажилсан	Өрмийн талбай	7 байршилд	Үйл ажиллагааны зардал	Талбайн бэлтгэл ажлын үед	MNS 6200:2010

### 1.14 Осол, эрсдэлийн менежментийн хэрэгжүүлсэн ажлын фото зургууд

Туршилт олборлолтын талбайтай танилцахаар ирсэн зочдод талбайд ажиллах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдлын заавар зөвлөмж өгч буй байдал



**Зураг 47. Зочдод аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал**

Талбайд ажиллахын өмнө бүх ажилчдад ажлын талаарх заавар зөвлөмж өгөхөөс гадна аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг талбайн инженер болон ХАБ-ын ажилтан өгч ажилсан.



**Зураг 48. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал**

Өрмийн гэрээт байгууллагууд кемпийн гадна галын сарааг заавал байршуулахаас гадна галын аюулгүй ажиллагааны самбарыг шуурдлагатай газруудад байршуулсан.



**Зураг 49. Кемпүүдийн гадна байршуулсан галын аюулгүй байдлын багаж хэрэгслүүд**

Галын аюулгүй байдлыг хангах үүднээс галын хорыг зохих байршлуудад байршуулсан.



**Зураг 50. Галын аюулгүй байдлын самбар, хор байршуулсан байдал**




**Зураг 51. Авто зогсоолын дэргэд галын хор байршуулсан байдал**

Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээт байгууллагууд ажилчдаа хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажилсан.



**Зураг 52. Ажлын хувцас хэрэглэлээр бүрэн хангагдсан байдал**



Зураг 53. Анхны тусламжийн самбар байршуулсан байдал



Зураг 54. Анхны тусламжийн хайрцаг буюу эмийн байршуулсан байдал

#### 1.14.1 Өрөмдлөгт ашиглаж буй зарим химийн бодис туслах материал

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “химийн хорт бодис” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг; 3.1.2 дахь хэсэгт “химийн аюултай бодис” гэж

тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг ойлгоно. Хадгалалт, зарцуулалт, агуулахын бүртгэл, аюулгүй ажиллагааны заавар журам, тээвэрлэлт гэсэн зарчим баримталсан.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5.1-д зааснаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.3-т тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах үйл ажиллагаа эрхлэх аливаа төсөл нь Монгол Улсын Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу химийн бодисын эрсдэлийн үнэлгээг заавал хийлгэнэ. Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд хийгдэх ба үнэлгээний тайлангийн бүрдэл хэсэг байна. Мөн энэхүү эрсдэлийн үнэлгээнд химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг Жи Өү Эйч ХХК БОННУ тайлан хийлгэсэн. Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис болон түүнийг ашиглахтай холбоотой аж ахуй нэгжид өгдөг зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн хуулбарыг хавсралтаар орууллаа. Тухайн хайгуулын ажлын хүрээнд дизель түлш, бентонит, уламжлалт туслах материал ашигласан. Шавар уусмалын найрлага, шинж чанар, физик үзүүлэлт зэргийг өрөмдлөгийн явцад цооногт орох, гарах хэсгээс авч хэмжилтийг байнга хийж хяналт тавин ажилласан.

1. Дизель түлш - цооног өрөмдөгийн үйл ажиллагаанд ашиглагдах хүнд машин, техникт ашиглагдахаас гадна өрмийн кемпийн цахилгааны эх үүсвэр болох дизель моторт хэрэглэгдэнэ. Энд машин техник, тээврийн хэрэгслийн түлш, автобензин, тосолгооны материалын хангамжийг хээрийн ажил гүйцэтгэх газрын ойр орчмын сумын төв, суурин газраас худалдан авах ба тусгайлсан хадгалах агуулах, сав байршуулах шаардлагагүй, Зориулалтын цистернээр тээвэрлэн авчир, талбайд байршуулна.
2. Бентонит - өрөмдлөгийн үйл ажиллагаанд цооногийн нүхний ханын нуралтаас хамгаалан ханыг бэхжүүлэх хэрэглэнэ.
3. Туслах материал – өрөмдлөгийн шавар уусмалд бага хэмжээгээр нэмэх угаалгын бодисууд өрмийн цементац, цооног битүүлэх, өрмийн шавар уусмалын угаалгад ашиглана. Өрөмдлөгийн нэвтрэх хурд, чанар, цооногийн хананы нуралтаас сэргийлэхэд ашиглагдана.
4. Цемент – цооногийг битүүмжлэн хаахад хэрэглэнэ

**Тээвэрлэлт:** Химийн хорт болон аюултай бодисыг Монгол Улсын Засгийн газрын 2006 оны (2010 онд нэмэлт өөрчлөлт орсон) 296 дугаар тогтоолоор батлагдсан

“Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай” тогтоолд тусгагдсан зөвшөөрөгдсөн улсын хилийн боомтоор нэвтрүүлж, аюултай ачаа бараа тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тээвэрлэлтийг гүйцэтгүүлнэ.

**Хадгалалт:** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу химийн бодисын агуулахын зориулалттай ажлын байрыг “MNS 6458:2014 Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, ерөнхий шаардлага” стандартын шаардлагад нийцүүлэн зориулалтын дагуу тохижуулж, хадгална. Химийн хорт болон аюултай бодисын ангилал

Химийн бодис, материалын хор, аюулын ангилал нь НҮБ-аас гаргасан GHS (Globally Harmonized System of Classification and Labeling of Chemicals) буюу химийн бодисуудын ангилал ба зэрэглэлийн дэлхий нийтийн зохицуулалтын систем байдаг. НҮБ-ын GHS системийг Европийн Холбооны улсууд болон АНУ хуулиндаа CLP (Classification, Labelling and Packaging) буюу химийн бодисуудыг “Ангилал, Зэрэглэх ба Хаягжуулах” журам нэрээр тусган, мөрдөж байна.

Химийн бодисуудын хор, аюулын ангилал болон зэрэглэлийн GHS (Globally Harmonized System) систем буюу Дэлхий нийтийн зохицуулалтын системийн нэг хэсэг бөгөөд тэдгээр нь химийн дан болон холимог бодисуудын хор, аюулын талаар иж бүрэн стандарт тэмдэглэгээг дэлхий нийтийн хэмжээнд бий болгох зорилгыг агуулсан болно.

Химийн хорт болон аюултай бодисуудын хор, аюулын ангилал, зэрэглэлийн элементүүд болон аюулын нэмэлт тэмдэглэгээг GHS/CLP-Дэлхий нийтийн зохицуулалтын системийн стандарт аргачлал болон БОНХАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2015 оны 10 сарын 08 өдрийн А/356/396 тоот хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын ангилал”-ыг ашиглан хор аюулын лавлах мэдээлэл зэргийг материал хадгалах агуулах д байршуулан ажилласан.

Өрмийн шингэнийг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалж хор аюулын лавлах мэдээллийг байршуулж мөн асгаралт үүссэн үед яаралтай авах арга хэмжээний төлөвлөлт зэргийг байршуулан ажилласан.

Химийн бодисын хадгалалтын горим алдагдах, санамсаргүй байдлаар асгах зэргээр ажилчид (хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажилласан тохиолдолд) химийн бодисын тоос, уураар амьсгалах, гар нүд, арьс салст, хоол боловсруулах замаар хүрэлцэх, цочрох түлэгдэх зэргээр эрсдэлд өртөж болзошгүй. Асгарсан шингэн бодисуудыг элс, шороо, бусад идэвхигүй шингээгч

материал ашиглан шингээж авах, тухайн талбайг цэвэрлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Цэвэрлэгээнд ашигласан шингээгч материал, хаягдал бодисуудыг хаягдал хадгалах тусгай саванд тус тусад нь ангилан ялгаж шошгожуулан хадгалах ба ил задгай энгийн хог хаягдалтай хамт хаяхгүй арга хэмжээний төлөвлөлт хийж ажилласан.

## Бентонит

**Худалдааны нэр:** Aus-Gel (ерөмдлөгийн шавар)

**Химийн нэр:** Кальцийн /содийн монтморилонит (calcium/sodium montmorillonite)

**Химийн тэмдэглэгээ:**  $(\text{Na}, \text{Ca})_{0.33}(\text{Al}, \text{Mg})_2\text{Si}_4\text{O}_{10}(\text{OH})_2 \cdot (\text{H}_2\text{O})_n$

### Хүснэгт 12. Бентонитын физик шинж чанар

1	Үл норох гадаргуу (75 микрон хэмжээтэй ус үл нэвтрэх )	80 %
2	Чийгтэй гадаргуу	2%
3	Гол хэсгийн нягт	0.9
4	Шингэний хязгаарлал	500%
5	Чийгийн агуулга	10%
6	Катионы солилцооны багтаамж	85

### Хүснэгт 13. Бентонитын химийн шинж чанар, ерөнхий агууламж

1	Цахиурын оксид $\text{SiO}_2$	68.8%
2	Хөнгөнцагааны оксид $\text{Al}_2\text{O}_3$	13.6%
3	Төмрийн оксид $\text{Fe}_2\text{O}_3$	2.8%
4	Натрийн исэл $\text{Na}_2\text{O}$	2.3%
5	Магнийн исэл $\text{MgO}$	2.0
6	Кальцийн исэл $\text{CaO}$	0.25
7	Калийн исэл $\text{K}_2\text{O}$	0.2
8	Титаны оксид $\text{TiO}_2$	0.3
9	Ус $\text{H}_2\text{O}$	9.3

Саарал, шаргалдуу өнгөтэй, үнэргүй, усанд уусдаггүй, нунтаг бодис. Цооногийг угаах мөн дээжийг бэхжүүлэх зорилгоор ихэвчлэн (тунамал сэвсгэр хурдасанд) хэрэглэнэ. Бентонитийг устай хольж хэрэглэх бөгөөд чулуулагийн үйрмэг, мөхлөг хэсгүүдийг нэгтгэн доош сууж эхлэнэ. Бентонит нь цементийг бодвол суултын хугацаа хурдан, усыг нэгдүүлэх үед дулаан үүсдэггүй, гидростатик даралт бага эдийн засгийн хувьд өртөг бага тухайн хэмжээний бентонит нь тийм хэмжээний цементийн гуравны нэгийн өртөгтэй тэнцэнэ.



## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өрөмдлөгийн хайгуулын ажлын үед нэг гэрээт байгууллага нь 15 - 18 ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Хог хаягдлын менежментийн үйл ажиллагаатай холбоотой дараах арга хэмжээг авч ажилласан.

- Хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагаатай холбоотой орон нутагтай гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэлийг ханган ажилласан
- Кэмпийн үйл ажиллагаанаас гарах ахуйн хогийг ангилан ялгаж, хуримтлуулж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт тушаасан.
- Дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг орон нутгийн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэн зайлуулдаг.
- Хоолны үлдэгдэл, ногооны хаягдал зэргийг био уутанд хуримтлуулж орон нутгийн зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулдаг
- Кэмпийн ажилчдад зориулан био ариун цэврийн байгууламж, бакоши зэрэг эко бие засах газар байгуулсан.
- Өрмийн шавар уусмалыг хаягдлын санд төвлөрүүлэн, эргүүлэн ашиглаж, ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийгдсэн.
- 

Хог хаягдлын ангилал, зайлуулах: Түр кэмпээс гарч байгаа хог хаягдлыг ангилан ялгаж тусгай хогийн цэгт хуримтлуулан дахин ашиглах боломжтойг нь хоёрдогч түүхий эд авах цэгт тушаадаг бол бусад хог хаягдлыг гэрээний дагуу орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт хаяж устгадаг.

“Топ Даймонд Дриллинг” компани нь өрмийн түр кемпийн ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тусгай савнуудад хадгалан Баян - Овоо сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт хаяж устгадаг байна. Топ Даймонд Дриллинг компани нь өрмийн түр кемпийн хог хаягдлын цэгийн зургийг фото зургаар үзүүлэв.

**Хүснэгт 14. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Кемпийн үйл ажиллагаанаас гарах ахуйн хогийг ангилан ялгаж хуримтлуулах	Кемпийн үйл ажиллагаанаас гарсан ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хуримтлуулсан	Ахуйн хог хаягдал	Жил/тн	3-4	Үйл ажиллагааны зардал Туслан гүйцэтгэгч	Тухайн жилийн хайгуулын ажлын хугацаанд	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1, 10.2.5, 10.2.8
2.	Дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг орон нутгийн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэн зайлуулах	Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусад нь хуримтлуулан хоёрдогч түүхий эд авах цэгт тушаан борлуулсан. Шил, лааз, хуванцар гэх мэт.	Ахуйн хог хаягдал	7 хоногт 1 удаа	1-2	Үйл ажиллагааны зардал Туслан гүйцэтгэгч	Тухай бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.4
3.	Үйл ажиллагаа явуулах сумын захиргаатай хог хаягдлын гэрээ байгуулж, төлбөр төлнө	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан ажилсан <b>/гэрээг хавсралт 5-д үзүүлэв/.</b>	Ахуйн хог хаягдал	Үнэ, тариф	4	1 468 000 Туслан гүйцэтгэгч	Гэрээг үйл ажиллагаа эхлэхэд байгуулж, төлбөрийн сар бүр төлнө Туслан Гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3; 10.2.7
4.	Хоолны үлдэгдэл, ногооны хаягдал зэргийг био уутанд хуримтлуулж, ялзмагжуулах	Хоолны үлдэгдэл, ногооны хаягдал зэргийг тусад нь хуримтлуулан хаяж устгасан.	Органик хаягдал	ш	42 ш	172 200 Туслан гүйцэтгэгч	Хээрийн ажлын шатанд байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.8

	(Уут задрах эрсдлээс хамгаалж уутыг давхарлана).							
5.	Кемпийн ажилчдад зориулан эко бие засах газар байгуулах	Түр кэмпүүдэд био нойлтой байх шаардлага тавин ажилсан.	Ахуйн бие засах газар	удаа	1	2 000 000 Туслан гүйцэтгэгч	Хээрийн ажлын шатанд Туслан гүйцэтгэгч	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.13
6.	Кемпийн ойр орчны хог хаягдлыг цэвэрлэх	Тогтмол цэвэрлэсэн бөгөөд талбайг хүлээлгэн өгөхийн өмнө тухайн орчны бүрэн цэвэрлэж орон нутагт хүлээлгэн өгсөн.	Амралтын байр, хоолны газар, машин парк	7 хоногт	1-2	-	Үйл ажиллагааны явцад	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.13 болон гэрээний дагуу
7.	Өрмийн шавар уусмалыг хаягдлын санд төвлөрүүлэн, эргүүлэн ашиглаж, ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийх	Өрмийн шингэн хаягдлыг тусгай санд хуримтлуулан өрөмдлөг дууссаны дараа дараагийн өрөмдлөгт дахин ашигласан. Өрмийн сангийн талбайг стандартын дагуу бүрэн нөхөн сэргээж талбайг орон нутагт хүлээлгэн өгсөн	Үйлдвэрлэлийн хаягдал	м <sup>3</sup>	10	Нөхөн сэргээлтийн зардал	Өрмийн ажил дууссаны дараа Туслан гүйцэтгэгч тал	MNS 6200:2010, Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх
8.	Химийн бодисын сав, баглаа боодлыг аюултай хог хаягдал хүлээн авах мэргэжлийн байгууллагуудад тушааж, актаар хүлээлцэх	Химийн бодисын сав, баглаа боодлыг аюултай хог хаягдал хүлээн авах Цэцүүх трейд ХХК -д тушаасан бөгөөд актыг зураг 63-д үзүүлэв.	Ангилсан хаягдал	тн	-	Үйл ажиллагааны зардал Туслан гүйцэтгэгч	3-р улиралд Туслан гүйцэтгэгч тал	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5, 23 дугаар зүйл

### 1.15 Хог, хаягдлын менежментээр хэрэгжүүлсэн ажлын фото зургууд

Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хэрэгжилтийг энэ хэсэгт фото зургаар үзүүлэв.



**Зураг 55. “Топ Даймонд Дриллинг” компани түр хогийн цэг**

Туршилтын олборлолтын талбайн үйл ажиллагааг Монбаг ХХК хариуцан ажилладаг бөгөөд ахуй хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг Номгон сумын хог хаягдлын цэгт гэрээний дагуу хаяж устгадаг байна. Туршилтын олборлолтын талбайн хог хаягдлын цэгийг хөрсөнд бохирдолт үүсгэхгүй байх үүднээс үл нэвчүүлэх пилонкоор дэвсэж хамгаалсан.



**Зураг 56. Туршитын олборлолтын талбайн хог хаягдлын цэг**

Ахуйн гаралтай шингэн хаягдлыг тусгай цооногт хуримтлуулан сард 2 удаа соруулан Номгон сумын цэвэрлэх байгууламжид гэрээний дагуу нийлүүдэг байна.



**Зураг 57. Туршилтын олборлолтын талбайн шингэн хаягдлын цооног**



**Зураг 58. Кемдүүд ахуйн хог хаягдлыг 3-4 хэсэг болгон ангилан ялгадаг**

Бид 2022 оноос эхлэн хайгуул өрөмдлөгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа түр кэмпүүдийг аль болох нүхэн жорлон ашиглуулахгүй байх үүднээс био нойл ашиглах шаардлага тавин ажиллаж байна.



**Зураг 59. Био нойл байршуулсан байдал**



**Зураг 60. Хоолны үлдэгдэл хуримтлуулах сав**

Кемп бүр тусгай цэгт тамхи татах цэгүүдийг байгуулан ажилсан бөгөөд өдөр бүр тамхи татах цэгийн ойр орчмыг цэвэрлэж ажилласан.



**Зураг 61. Тамхи татах цэг байгуулсан байдал**

Өрмийн шингэн хаягдлыг үл нэвчүүлэх пилонкоор доторлосон тусгай санд хуримтлуулсан бөгөөд өрөмдлөгийн ажид дууссаны дараа стандартын дагуу нөхөн сэргээлт хийн талбайг орон нутагт хүлээлгэн өгсөн.



**Зураг 62. Өрмийн шингэн хаягдлыг тусгай санд хуримтлуулан байдал**

Өрөмд ашигласан шингэнээ буцааж соруулж дараагын өрөмдөх цооногын зүүмпрүү зөөж дахиг ашиглаж буй зураг.



**Зураг 63. Өрөмд ашигласаг шингэнийг соруулж буй байдал**



тушаалын 1 дүгээр хавсралт

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ 0000618

Дагалдах бичгийн дугаар:  
/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ./

<b>1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:</b> Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: <u>Монгол ургамалт</u>																																																						
<b>2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:</b> Овог нэр: <u>Солонго баяр</u> Албан тушаалтан: <u>Хүний нөөцийн</u> Гарын үсэг: <u>[Signature]</u> Огноо: 2023 он 09 сар 29 өдөр																																																						
<b>3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:</b> 1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: <u>76-05 4HO</u> Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:																																																						
<b>4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:</b> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse; text-align: center;"> <thead> <tr> <th rowspan="2"></th> <th rowspan="2">Аюултай хог хаягдлын нэр</th> <th rowspan="2">Аюулын ангилалын зэрэглэл</th> <th rowspan="2">Савлаганы бүлэг</th> <th colspan="2">Савны</th> <th rowspan="2">Хэмжээ</th> <th rowspan="2">Нэгж /кг Эсвэл/ш</th> <th rowspan="2">Аюултай хог хаягдлын код</th> </tr> <tr> <th>дугаар</th> <th>Төрөл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td><u>Шуудай</u></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td><u>300</u></td> <td><u>кг</u></td> <td><u>150109</u></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>4</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>									Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлаганы бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ш	Аюултай хог хаягдлын код	дугаар	Төрөл	1	<u>Шуудай</u>					<u>300</u>	<u>кг</u>	<u>150109</u>	2									3									4								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлаганы бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ш					Аюултай хог хаягдлын код																																										
				дугаар	Төрөл																																																	
1	<u>Шуудай</u>					<u>300</u>	<u>кг</u>	<u>150109</u>																																														
2																																																						
3																																																						
4																																																						
<b>3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:</b>																																																						
<b>5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:</b>																																																						
1. Овог нэр: <u>С. Талманцга</u> Гарын үсэг: <u>[Signature]</u> 2023 он 09 сар 29 өдөр																																																						
<b>6. Үл зохицол:</b>																																																						
<b>7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:</b> Аж ахуйн нэгжийн нэр: <b>ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК</b> Цэцүүх трейд ХХК бүртгэлийн дугаар: <b>У-001123</b> Аюултай хог хаягдлыг хүлээн авсан. Овог нэр: <u>Цэцүүх трейд ХХК</u> Албан тушаал: <u>ИТМАН</u> Гарын үсэг /тамга/: <u>[Signature]</u> Огноо: 2023 он 09 сар 29 өдөр																																																						

Зураг 64. Аюултай хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК -л тушаасан акт

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Номгон IX талбайн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 2023 онд агаар чанар, хөрсөн бүрхэвч, ус, ургамал нөмрөгийн чиглэлээр 1-2 удаагийн давтамжтай хэрэгжүүлсэн бөгөөд үр дүнг боловсруулан энэ бүлэгт авч үзлээ. Уг агаарын чанар мониторинг судалгаагаар өрөмдлөгийн талбайн хүхэрлэг хий, азотын давхар исэл, агаарын нийт тоосны агууламж нь MNS4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нийцэж буй эсэхийг тодорхойлоход гол зорилго оршино.

### 1.16 Агаарын чанар

Агаарын чанарын орчны хяналт шинжилгээний хүрээнд 1-2 удаагийн давтамжтай 10 цэгээс дээж авч шинжлүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд уг төлөвлөгөөгөөр 9-10 цэгт хайгуулын өрөмдлөг хийхээр төлөвлөж байсан бол 2023 онд 7 цооног өрөмдсөн учир 7 цэгт хэмжилт хийхээс гадна мод үржүүлгийн талбайд нэмэлт хэмжилт хийж агаарын чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулан үр дүнг боловсруулсан.

#### 1.16.1 Судалгааны аргазүй

Монгол Улсын агаарын чанарын Агаар мандал Сорьц авах ерөнхий шаардлага MNS 3384:82, Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS 17.2.5.11-88, Агаар дахь хүхрийн хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS 17.2.5.12-88 стандартын дагуу нэг агшны хөндлөн огтлолт судалгааны загвараар тухайн нөхцөл дэх уртраг, өргөргийн тодорхой солбилцолд тоосны хэмжилтийг нийт тоос /TSP/, нарийн ширхэглэгт тоосонцор /PM<sub>2.5</sub>/, том ширхэглэгт тоосонцор /PM<sub>10</sub>/ үзүүлэлтээр DUSTTRAK II Aerosol Monitor DRX багажаар, Хүхэрлэг хий болон Азотын давхар исэлийг SKC Pocket Pump TOUCH, MP-ΣNII Series багажуудаар 20 минут хэмжсэн. Дээжийг лабораторийн орчинд азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийг нэг удаагийн агууламжийг шингээгч гуурсанд 0.25 л/мин-ын хурдтай 20 спектрофотометрийн аргаар, хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/-г нэг удаагийн агууламжийг шингээгч гуурсанд 0.5 л/мин-ын хурдтай 20 минутын турш соруулж тетрахлормеркурат /TХМ/ натрийн аргаар тодорхойлсон. Судалгааны үр дүнг агаарын чанарын стандарт (MNS 4585:2016)-тай харьцуулж дүгнэлт өгсөн.

Агаарын хэмжилт хийж байх үеийн фото зургуудыг доор үзүүлэв.



Өрөмдлөг хийсний дараах хэмжилт



Өрөмдлөг хийж байх үеийн хэмжилт


Туршилт олборлолтын талбайн хэмжилт

**Зураг 65. Агаарын чанарын хэмжилт хийж буй байдал**

Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүд

№	Агаарын хэмжилт хийсэн цэгүүдийн нэр	Солбицол	
		ХӨ	ЗУ
1	BlueBill-1S	42.88409444	105.6954639
2	Nomgon-10	42.87238611	105.4714361
3	Big Slope-7	42.92704722	105.2376667
4	Big Slope Shallow-1	42.92696389	105.2397389
5	Big Slope West-1S	42.93614444	105.2026583
6	Yangir Far West-1	42.93675833	105.1006722
7	Yangir West-2	42.92843611	105.1015139
8	Mod urjuuleg	42.84984722	105.129975

Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдийн байршлыг доорх зургаар үзүүлэв.



Зураг 66. Агаарын чанарын дээж авсан цэгүүдийн байршил

### 1.16.2 Агаарын чанарын шинжилгээний дүн

Агаарын чанарын шинжилгээний дүнгээс үзвэл агаарын чанарын дээжийн шинжилгээний дүн нь MNS 4585:2016 агаарын чанарын техникийн ерөнхий шаардлагын бохирдуулагч бодис болон физик бохирдуулагчийн хүлцэх агууламжаас бага стандартын шаардлага хангаж байна.

#### Хүснэгт 15. Агаарын чанарын шинжилгээний дүн


Дээж авсан огноо	Хэмжилт хийсэн цэг	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> / мкг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл /NO <sub>2</sub> / мкг/м <sup>3</sup>	Тоосонцор /20 минутаар/		
				Нийт тоос мкг/м <sup>3</sup>	PM 2.5 мкг/м <sup>3</sup>	PM 10 мкг/м <sup>3</sup>
2023.01.08	Цогтцэций сум	8	14		33	41
2023.10.09	Yangir Far west	9	38	47		
	Blue bill-1 s	11	18	74		
	Туршилт олборлолтын талбай Номгон-8	17	21	73		

Дээж авсан огноо	Хэмжилт хийсэн цэг	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /	Азотын давхар исэл /NO <sub>2</sub> /	Тоосонцор /20 минутаар/		
				Нийт тоос	PM 2.5	PM 10
		мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>
	Туршилт олборлолтын талбай Номгон-9	10	23	60		
	Туршилт олборлолтын талбай Номгон-10	32	19	13		
	Bid slope-7	21	15	251		
	Big slope west 1s	23	17	88		
	Yangir Far west-2	18	14	84		
	Номгон мод үржүүлгийн талбай	27	34	66		
	<b>MNS 4585:2016</b>	450	200	500	50	100

**Хүхэрлэг хийн агууламж:** Хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/ нь хүхэр агуулсан түлшний шаталтаас үүсэх бөгөөд орчныг бохирдуулагч хортой хий. Хүхэрлэг хий нь нүүрс ашигладаг дулааны цахилгаан станц, үйлдвэр, металлург, гангийн үйлдвэр, нүүрс шатаадаг ахуйн зуух, тээврийн хэрэгсэлийн түлшний шаталтаас үүснэ. Хүхэрлэг хийний хоруу чанар нь өндөр концентрацитай үед амьсгал давчдах, хоолой хорсох гэх мэт шинж тэмдэг илэрдэг бөгөөд амьсгалын замын эрхтэний системийг гэмтээдэг.

SO<sub>2</sub>+H<sub>2</sub>O+O<sub>2</sub>→H<sub>2</sub>SO<sub>4</sub> урвалаар томоохон хот, үйлдвэрийн бүсэд хүхэрлэг хийн өндөр концентраци нь усны ууртай нэгдэж хүчиллэг тундас (H<sub>2</sub>SO<sub>4</sub>) үүсгэдэг. Энэ химийн нэгдэл нь маш хүчиллэг шинжтэй бөгөөд агаарт дэгдэж борооны устай хамт газар буудаг. Хүний эрүүл мэндэд ялангуяа арьс, үсэнд хортой. Барилга байгууламжийг аажмаар элэгдүүлдэг байна.


Бидний хийсэн хэмжилтийн үр дүнгээс харахад хүхэрлэг хийн агууламж хамгийн ихдээ туршилт олборлолтын талбайд 32 мкг/м<sup>3</sup> хамгийн багадаа 8 мкг/м<sup>3</sup> байна. Хамгийн өндөр үр дүн болох 32 мкг/м<sup>3</sup> нь Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад 14 дахин бага буюу бохирдолтгүй байна.



Зураг 67. Хайгуулын талбайн цооногуудын орчмын азотын давхар ислийн агууламж

**Азотын давхар исэл:** Азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ) нь өндөр температуртай шаталтын үед дулаан шингэх урвалын үр дүнд үүсэх бөгөөд хүрээлэн байгаа орчны бохирдлын бас нэг шалтгаан юм. Гол эх үүсвэр нь тээврийн хэрэгсэлийн шатахууны шаталт, дулааны цахилгаан станц гэх мэт. Газрын гадарга дээрх озон нь азотын давхар ислийн дам бүтээгдэхүүн бөгөөд хүчтэй исэлдүүлэгч тул озоны агууламж ихэсвэл амьтан ургамалын гаднах эд эсийг гэмтээдэг. Азотын исэлүүд нь амьсгалын замын цочмог үрэвсэл, багтраа бронхит үүсгэх нөлөөтэй. Азотын ислүүд нь ( $\text{NO}$ ,  $\text{NO}_2$ ,  $\text{N}_2\text{O}$ ) агаарын бохирдлын химийн хувиралд гол нөлөө үзүүлдэг. Азотын ( $\text{NO}_x$ ) ислүүдийнхэнх хувийг шаталтаас үүссэн азотын исэл эзэлдэг бөгөөд шаталтаар ялгарч буй хий нь  $2\text{NO} + \text{O}_2 \rightarrow 2\text{NO}_2$  (1) процессоор азотын давхар ислийг бий болгодог.

Бидний судалгааны талбай буюу ерөмдлөгийн цэгүүдэд хийсэн хэмжилтийн үр дүнгээс харахад азотын давхар исэл агууламж хамгийн ихдээ Yangir Far west -1 цооног орчимд  $38 \text{ мкг/м}^3$  хамгийн багадаа  $14 \text{ мкг/м}^3$  байна. Хамгийн өндөр үр дүн болох  $38 \text{ мкг/м}^3$  нь Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад 5 дахин бага буюу бохирдолтгүй байгаа нь доорх үр дүнгээс харагдаж байна.



Зураг 68. Хайгуулын талбай буюу цооногуудын азотын давхар исэлийн агууламж

**Тоосны агууламж:** Хот суурин газрын агаарт янз бүрийн эх үүсвэрээс үүдэлэй тоос тоосонцор байх ба тэдгээрийн аэродимак хэмжээ, химийн найрлага, усанд уусах шинж чанар, гэрлийг шингээх, ойлгох, орчны агаар дахь агууламж зэргээс хамаараад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байдаг. Агаар мандалд 0.001-100 микрометр ширхэглэлийн хэмжээтэй тоос тоосонцор түгээмэл илрэх ба ширхэглэлийн хэмжээ (аэродинамик диаметр)-нээс хамаарсан агууламжын тархалтын гол онцлогийг доорх зургаар үзүүлэв.




Зураг 69. Агаар мандал дахь тоосонцоруудын харьцангуй агууламж

Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдээс ялгарч буй хаягдал дахь хортой хийнүүд нь орчны агаарын чанарт шууд нөлөөлөхөөс гадна агаар мандал дахь физик, химийн процессуудын үр дүнд илүү хоруу чанартай химийн нэгдлүүд, нарийн ширхэглэлтэй тоосонцрыг үүсгэж байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын байгаль орчин, эрүүл мэндийн судалгааны төвүүдээс хүрээлэн буй орчны агаар дахь тоосонцрыг хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд үндэслэн тогтоосон зөвшөөрөгдөх агууламжын хэмжээнд хянаж байхыг зөвлөсөн байдаг. PM10 буюу 10 микроноос бага ширхэглэлийн хэмжээтэй тоосонцор нь илүү их хор хөнөөлтэй химийн элемент, нэгдлүүдийг агуулж байдаг ба хүний амьсгалын эрхтнүүдээр шүүгдэж хуримтлагддаг байна.

Харьцангуй том ширхэглэлтэй тоос тоосонцор нь ам болон хамараар шүүгдэж гадагшлах боломжтой бол илүү нарийн ширхэглэлтэй тоосонцор нь уушигны цулцан цаашлаад цусаар дамжин бүх эд эрхтэнд хуримтлагдах аюултай. Зарим маш нарийн нано хэмжээтэй тоосонцор нь хамрын нармайгаар дамжин тархинд шууд хуримтлагдаж байдаг. Мөн тоосонцорт агуулагдах усанд уусах шинж чанартай хортой хүнд металлууд, химийн нэгдлүүд хүний эрхтэнд үйлчлэх нь уусамтгай биш нэгдлүүдтэй харьцуулахад илүү хурдан байдаг.

Бидний судалгааны талбай буюу өрөмдлөгийн цэгүүдэд хийсэн хэмжилтийн үр дүнгээс харахад тоосны агууламж хамгийн ихдээ Bid slope-7 цооног орчимд 251 мкг/м<sup>3</sup> хамгийн багадаа 13 мкг/м<sup>3</sup> байна. Хамгийн өндөр үр дүн болох 251 мкг/м<sup>3</sup> нь Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад 2 дахин бага буюу бохирдолтгүй байгаа нь доорх үр дүнгээс харагдаж байна.



Зураг 70. Хайгуулын талбайн цооногууд талбайн тоосны агууламж 2023 он



## 1.17 Хөрсний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэл

Бид “Жи Өү Эйч” ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээт “Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Номгон IX” талбайд 2023 онд хийгдсэн хайгуулын өрмийн цооногууд болон туршилт олборлолтын талбайд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсний мониторинг судалгааг 2023 оны 10 сарын 7-10 -ны хооронд хийж гүйцэтгэлээ.

### 1.17.1 Судалгааны аргазүй

**Хээрийн судалгаа:** Хөрсний хээрийн судалгаагаар хөрсний мониторингийн цэгүүдээс хөрсний ерөнхий хими, физик шинж чанар, хөрсний хүнд элементийн агууламж, хөрсний биологийн бохирдол /хөрсний эрүүл ахуйн/ дээжлэлтийг урьдчилан төлөвлөсөн цэг болон маршрутын дагуу хийж гүйцэтгэлээ. Судалгааны талбайд зонхилон тархсан хөрсөн бүрхэвчийг төлөөлүүлж 16 цэгээс 0-10, 10-20, 20-30, см гүнээс дээжлэлт хийн нийт 16 ширхэг дээжийг “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримтлан авсан.


#### Хүснэгт 16. Дээжлэлт хийсэн цэгүүдийн мэдээлэл

№	Цэгийн нэр	Дээжний зориулалт	Уртраг	Өргөрөг
<b>Хайгуулын цооногууд</b>				
1	BlueBill-1S	Агрохими, хүнд элемент	105° 41' 43.67"	42° 53' 02.74"
2	Big Slope-7	Агрохими, хүнд элемент	105° 14' 15.60"	42° 55' 37.37"
3	Big Slope Shallow-1	Хүнд элемент	105° 14' 23.06"	42° 55' 37.07"
4	Big Slope West-1S	Агрохими, хүнд элемент	105° 12' 09.57"	42° 56' 10.12"
5	Yangir Far West-1	Агрохими, хүнд элемент	105° 06' 02.42"	42° 52' 12.33"
6	Yangir West-2	Агрохими, хүнд элемент	105° 06' 05.45"	42° 55' 42.37"
7	Номгон-10 цооног	Хүнд элемент	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
<b>Туршилт олборлолтын талбай</b>				
8	Номгон-8 цооног	Хүнд элемент, эрүүл ахуй	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
9	Номгон-9 цооног	Хүнд элемент	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
10	ТО -ын талбайд	агрохими	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
11	Хогийн цэг	Эрүүл ахуй	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
12	Цэвэрлэх байгууламж	Эрүүл ахуй	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
13	ажилчдын сууц	Эрүүл ахуй	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
14	Нүхэн жорлон	Эрүүл ахуй	105° 28' 17.17"	42° 52' 20.59"
15	Байгалийн хөрс	Агрохими, хүнд элемент	105° 28' 15.49"	42° 52' 15.49"
<b>Мод үржүүлгийн талбай</b>				
16	Мод үржүүлэг	Агрохими, хүнд элемент	105° 07' 47.91"	42° 50' 59.45"


**Лабораторийн шинжилгээ:** Хөрсний ерөнхий физик, хими, хүнд элементийн агууламж, хөрсний эрүүл ахуйн үзүүлэлтийг тодорхойлуулна. Судалгааны талбайгаас нийт ерөнхий хими, физик тодорхойлох 11 ш дээж, хүнд элементийн агууламж тодорхойлох 11 ш дээж, хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт тодорхойлох 5 ш дээжийг авч бэлтгэв. Эдгээр дээжийг магадлан итгэмлэгдсэн лабораториудад шинжлүүлж, гарсан үр дүнг нэгтгэн тайланг боловсруулсан. Хөрсний ерөнхий

хими, физик, хүнд элемент, эрүүл ахуйн үзүүлэлтүүдийг “Инженер геодези” ХХК-ий Хөрс-Агрохимийн магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

**Зураглалын судалгаа:** Хээрийн судалгааны үед DJI Mavic 3E дрон ашиглан агаарын ортофото зургуудыг авч туршилт, олборлолтын талбайд бүрэн хэмжээний зураглал хийж Agisoft Photoscan програм дээр боловсруулалт хийсэн. Мөн талбайн гадаргын өндөршил болон хөрсөн бүрхэвчийн тархалтын зургийг ArcGis 10.8.2 програм дээр хийж гүйцэтгэлээ.



Зураг 71. Хөрсний мониторингийн цэг болон талбайн өндөржилт




**Зураг 72. Туршилт, олборлолтын талбай болон дээж авсан цэгийн байршил**

### 1.17.2 Хөрсний мониторинг судалгааны үр дүн

“Номгон IX” талбай нь Монгол орны хөрс газарзүйн мужлалтын хувьд Говийн хөрсний их мужийн өргөрөгийн бүсшилтэй нутгийн Заримдаг цөлийн Цайварбор, цөлийн Борсаарал хөрсний бүсийн Галбын говийн 14-р тойрог, Заг Сүүж-Борзонгийн говийн 15-р тойрог, өндрийн бүсшилтэй нутгийн Говь Алтайн мужийн Алтайн чанадахь 53-р тойрогт хамаарагдана.

Хөрсний ерөнхий тархалтын хувьд авч үзвэл уулархаг хэсгээр Чулуурхаг Бор, Цайвар бор хөрс, тал хөндий, нам толгодорхог хэсгээр сайргархаг, элсэрхэг Цайвар бор, Бор саарал хөрс зонхилон тархсан бол хөндий хотосын хэсэгт хужирлаг, мараалаг Цайварбор, Борсаарал, Шалархуу хөрс зонхилон тархана (зураг ..).

Харин 2023 онд хийгдсэн хайгуулын цооногууд болон туршилт олборлолтын талбай нь уулын энгэр, бэлийн орчимд байрлаж байна.



Зураг 73. Судалгааны талбайн хөрсөн бүрхэвчийн тархалт

**Уулын цөлийн бор саарал:** Энэ хэвшинжийн хөрс дээд талаараа уулын цөлөрхөг хээрийн (заримдаг цөлийн) бор хөрстэй хиллэж уулын хажуугийн дундаас доош хэсгээр голлож тархах бөгөөд баглуур, бударганат цөлийн ургамалшил маш сийрэг (бүрхэц нь 10-15%) ургаж хөрсний гадарга томовтор

чулуугаар хучигдсан байдаг. Чулуунууд нь цөлийн түлэнхий бараан хүрэн гандаастай, хөрсөнд шигдсэн биш гадарга дээр нь сул байрлалтай байна. Хөрс нь гадаргаасаа эхлээд нунтаг карбонатын хуримтлалтай, харин давсархаг шинж байхгүй. Хөрс нь бүхэлдээ шүлтлэг, их шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж 0.4-0.5%-иас үл хэтэрнэ. Цөлийн хөрсний морфологийн гол шинж болох сүвэрхэг шинжтэй хальслаг өнгөн үе муу илэрч, харин улаавтар бор өнгөтэй, нягт тогтоцтой Vt, Ca давхарга тод ажиглагдана. Сайр чулуу ихтэй учраас хөрсний үе давхаргууд мөн л тасалдаж алаг цоог шинжтэй байх бөгөөд нийт зузаан нь 20-25 см-ээс илүү гарах нь цөөн.

**Цөлийн бор саарал:** Жинхэнэ цөлийн хөрс манай орны урд хэсгээр тархаж улсын бүх нутгийн 9.3%-тай тэнцэх талбайг эзэлнэ. Түүний 6.9% нь хөндий хотгор, тал газраар, үлдсэн 2.4% нь уул толгодоор тархана. Сөөг, сөөгөнцөр, бутлаг ургамал зонхилсон цөлийн ургамалшил маш сийрэг тархай байдалтай, газрын гадаргын дөнгөж 5-10%-ийг бүрхэнэ. Ус чийг туйлын хомс, жилд дунджаар 50-90 см хур тунадас унахаас гадна өвөл хүйтэн, улирлын хөлдөлт 4 сар гаруй хугацаагаар үргэлжилдэг учраас хөрсөн дэх биологийн үйл явц маш боогдмол байна. Хөрсний хөлдөлтийн гүн өвөл 1-1.5 м хүрэх бөгөөд -10°C-ын температур хөрсөнд 25-30 см гүн нэвтэрдэг. Зуны хур борооны үед хөрсний дээд нимгэн үе чийглэгдэхэд биологийн үйл явц эрчимтэй явагдах нөхцөл бүрдэх авч түүний үргэлжлэх хугацаа маш богинохон байна. Хур бороогүй гантай жил ургамлын ургалт хөгжилт зогсоход хүрдэг.

### **1.17.3 Морфологи бичиглэл:**

**BlueBill-1S цооног:** Тус цооногийг Өмнөговь аймгийн Баян – Овоо сумын нутагт 2023 оны 6 сарын 10 -аас 7 сарын 28 -ны хооронд “Топ Даймонд Дриллинг ХХК” ХХК хийж гүйцэтгэсэн байна. Тус өрөмдлөгийн цэг нь жижиг аараг толгодорхог хэсэгт байрлах бөгөөд тухайн орчинд уулын цөлийн бор саарал хөрсний төлөөлөл тархсан байна. Өрөмдлөг хийсэн цэгийн ойр орчмын багахан талбайн хөрс, ургамал нөмрөг өрөмдлөгийн үйл ажиллагааны нөлөөгөөр талхлагдаж халцгайрсан байна. Харин өрөмдлөгийн талбайг тэгшилж цэвэрлэн техникийн нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн байна. Тухайн орчинд олон салаа зэрэгцээ зам үүсгээгүй нэг замын бодлогыг маш сайн хэрэгжүүлж ажилсан болох нь хээрийн судалгааны үед ажиглагдаж байв.

**Координат:** N – 42° 53' 02.74” E – 105° 41' 43.67”

**Гадаргын налуу:** 0-3°

**Хөрсний эвдрэл:** Сул

**Элэгдэл, эвдрэл:** Ус, салхи

**Ургамал бүрхэц %:** 0-10%



**Зураг 74. BlueBill-1S цооногийн газрын гадарга, зүсэлт**

**АВ: 0-8 см:** Хуурай, цайвар бор өнгөтэй, бөөмөн бүтэцтэй, ургамлын үндэс байхгүй, нүх сүв их, нягт их, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй, чулуу 10-20%

**Туршилт, олборлолтын талбай:** Тус талбай нь Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт Эмгэнбулаг багийн нутагт Их Өвгөнт уулын өмнөд хажууд байрлах бөгөөд тухайн орчинд уулын цөлийн бор саарал хөрсний төлөөлөл тархана. Туршилт олборлолтын 3 га талбайн хөрс, ургамлан нөмрөг талхлагдаж нөлөөлөлд өртсөн байна.

**Координат:** N 42° 52' 15.49" E 105° 28' 25.74"

**Хөрсний эвдрэл:** Сул

**Элэгдэл, эвдрэл:** Ус, салхи

**Ургамал бүрхэц %:** 10-20%



**Зураг 75. Туршилт, олборлолтын талбайн газрын гадарга, зүсэлт**

**A: 0-8 см:** Хуурай, бор өнгөтэй, самран бүтэцтэй, ургамлын үндэс алаг цоог тархалттай, нүх сүв их, нягт бага, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй, чулуурхаг

**AB: 8-30 см:** Хуурай, бор саарал өнгөтэй, үрлэн бүтэцтэй, ургамлын үндэс алаг цоог тархалттай, нүх сүв их, нягт бага, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй, чулуу ихтэй

**B: 30-50 см:** Хуурай, саарал өнгөтэй, үрлэн бүтэцтэй, ургамлын үндэс байхгүй, нүх сүв их, нягт бага, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй

**Big Slope-7 болон Big Slope Shallow-1:** Уг хоёр цооног нь Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт уулын ар хажууд байрлах бөгөөд энд уулын цөлийн бор саарал хөрсний төлөөлөл тархаж байна. Хээрийн судалгааны үед өрмийн үйл ажиллагаа явагдаж дууссан бөгөөд тухайн орчны хөрс, ургамал нөмрөг үйл ажиллагааны нөлөөгөөр талхлагдаж халцгайрсан байна. Өрмийн талбайд техникийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

**Координат:** N 42° 55' 37.37" E 105° 14' 15.60"

**Налуу:** 0-3°

**Хөрсний эвдрэл:** сул

**Элэгдэл, эвдрэл:** Ус, салхи,

**Ургамал бүрхэц %:** 30-40%



**Зураг 76. Big Slope-7 талбайн газрын гадарга, зүсэлт**

**A: 0-22 см:** Өлөн чийгтэй, бор өнгөтэй, бөөмөн бүтэцтэй, ургамлын үндэс алаг цоог тархалттай, нүх сүв бага, нягт их, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй

**В: 22-40 см:** Хуурай, цайвар бор өнгөтэй, үрлэн бүтэцтэй, ургамлын үндэс байхгүй, нүх сүв их, нягт их, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй

**Yangir Far West-2:** Тус цооног нь Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт сумын төвөөс хойшо 10 гаруй км зайд уулын хажуугийн доод хэсэгт буюу ар хажууд байрлах бөгөөд энд уулын цөлийн бор саарал хөрсний төлөөлөл тархана. Биднийг хээрийн судалгаа хийх үед өрөмдлөгийн үйл ажиллагаа дууссан өрмийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байв. Өрмийн үйл ажиллагааны улмаас бага хэмжээний талбайн хөрс, ургамал нөмрөг талхлагдаж техникийн нөлөөлөлд өртсөн байна.

<b>Координат:</b>	N 42° 55' 42.37" E 105° 06' 05.45"		
<b>Налуу:</b>	3-5°		
<b>Хөрсний эвдрэл:</b>	Сул		
<b>Элэгдэл, эвдрэл:</b>	Ус, салхи	<b>Ургамал бүрхэц %:</b>	20-30%



**Зураг 77. Yangir Far West-2 талбайн газрын гадарга, зүсэлт**

**А: 0-20 см:** Өлөн чийгтэй, цайвар бор өнгөтэй, самран бүтэцтэй, ургамлын үндэс сийрэг тархалттай, нүх сүв бага, нягт их, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй, чулуугүй


**В: 20-30 см:** Чийглэг, бор өнгөтэй, элсэрхэг бүтэцтэй, ургамлын үндэс байхгүй, нүх сүв бага, нягт их, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй, чулуугүй

#### **1.17.4 Ерөнхий хими, физик шинж чанар**

**Хөрсний ялзмагийн агууламж:** Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй эрдэс,



органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро, микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Ялзмагийн бодис их байх тусам хөрсний өнгө гүн хар болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг.




**Зураг 78. Мониторингийн цэгүүдийн хөрсний ялзмагийн агууламж, %**

Ялзмагийн агууламж 2% болон түүнээс доош байвал бага агууламжтай гэсэн ангилалд ордог. Дээрх хүснэгтээс харахад бүх дээжний ялзмагийн агууламж бага болон маш бага хэмжээнд байна энэ нь тухайн бүс нутгийн хөрсний онцлогтой шууд холбоотой юм. Туршилт олборлолтын талбайн гүний дээжинд ялзмагийн агууламж 1.59% буюу хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан боловч бага хэмжээнд байна. Мөн энэ цэгийн өнгөн хөрсөнд 1.05% буюу бага зэргийн ялзмагийн агууламжтай байна. Энэхүү цэгээс бусад бүх цэг ялзмагийн агууламж маш бага буюу үржил шимийн гол үзүүлэлт хангалтгүй байна. Yangir Far West-1 цэгт 0.19% байгаа нь хамгийн бага үзүүлэлттэй байна.

**Хөрсний урвалын орчин (pH):** Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Доорх үр дүнгээс харахад судалгааны талбайн хөрсний урвалын орчин pH 8.5-9.49 хооронд буюу маш хүчтэй шүлтлэг байгаа нь ургамал ургах тохиромж багатэй гэж үздэг энэ нь говь цөлийн ургамал тачир сийрэг байхад нөлөөлөх хүчин зүйл болдог байна. Тухайн хөрсний урвалын орчин хүчтэй шүлтлэг байгаа нь тухайн бүс нутгийн хөрсний онцлогтой шууд холбоотой юм.


Судалгааны талбайн мониторингийн цэг болох Yangir West-2 цэг дээр хамгийн бага хэмжээтэй буюу 8.5 илэрсэн боловч энэ нь мөн хүчтэй шүлтлэг орчинг үзүүлж байна. Тэгэхээр тухайн талбайн хөрсөн бүрхэвч бүхэлдээ хүчтэй болон маш хүчтэй шүлтлэг хөрстэй байна. Nomgon-10 цэгт 9.49 буюу маш хүчтэй шүлтлэг орчинтой байгаа байгаа нь хамгийн өндөр утгыг үзүүлж байна.



**Зураг 79. Хөрсний урвалын орчин /pH/**

**Хөрсний карбонат:** Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO<sub>3</sub>)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал,

боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ.




**Зураг 80. Хөрсний карбонатын агууламж**

Судалгааны дүнгээс харахад Yangir West-2 цэг дээр 4.28-5.6% карбонаттай гарсан бөгөөд энэ нь дунд зэргийн карбонатжсан хөрс гэдгийг илтгэж байна. Бүх цэгт карбонат илэрсэн байна. Nomgon-10 цэг дээр 2.47% гарсан бөгөөд дунд зэрэг карбонатжсан байна. Бусад цэгүүд сул карбонатжсан байна. Бүх цэгт карбонат илэрсэн нь үржил шимийн үзүүлэлт сул байгааг илэрхийлэх бөгөөд үржил шим сайтай хөрсөнд карбонат огт илэрдэггүй онцлогтой.

**Хөрсний цахилгаан дамжуулалт (ЕС<sub>1:2.5</sub>) буюу хялбар уусах давсжилт:** ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ЕС нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг.

Доорх зургаас харахад туршилт, олборлолтийн талбайн өнгөн хөрсөнд 4.23 dS/m буюу их давсархаг, гүний дээжинд 8.79 dS/m буюу хэт их давсархаг байна. Yangir West-2 цэгийн өнгөн хөрсөнд 3.31 dS/m буюу дунд зэрэг давсархаг, гүний дээжинд 1.39 dS/m буюу сул давсархаг байна. Мод үржүүлгийн талбай, Yangir Far West-1

цэг дээр 0.75 dS/m гарсан нь сул давсархаг орчинг үзүүлж байна. Бусад цэгүүд давсжилтгүй.




Зураг 81. Хөрсний цахилгаан дамжуулах чадвар

Хүснэгт 17. Хөрсний агрохими шинж чанар


Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	NO <sub>3</sub> мг/100г	CaCO <sub>3</sub> , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
YFW-1	-	8.60	0.35	0.749	0.19	0.16	0.82	3.7	3.4	0.6	80
Yangir West-2	0-20	8.50	1.60	3.310	0.21	0.22	5.60	7.4	6.0	0.6	53
	20-30	8.76	0.65	1.390	0.22	0.15	4.28	5.5	3.6	0.6	28
Мод үржүүлэг	0-10	8.60	0.92	1.942	0.28	0.31	1.32	7.9	4.0	1.7	74
BSW-1S	0-10	8.89	0.12	0.265	0.28	0.17	0.99	6.8	2.6	0.8	73
T/O талбай	0-8	8.96	2.07	4.230	1.05	0.61	0.99	12.4	7.6	2.5	51
	8-30	9.04	4.43	8.790	1.59	0.38	2.47	23.8	11.9	2.7	42
Big Slope-7	0-22	9.10	0.12	0.274	0.35	0.41	1.32	7.8	4.0	1.2	51
	22-40	9.08	0.12	0.252	0.33	0.29	1.48	9.2	4.8	1.3	23
BlueBill-1S	0-30	8.96	0.10	0.218	0.86	0.52	1.15	8.5	3.0	1.6	44
Номгон - 10	0-10	9.49	0.15	0.333	0.25	0.27	2.47	7.6	5.0	1.9	67

**Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P<sub>2</sub>O<sub>5</sub>, K<sub>2</sub>O):** Хөрсний азот, фосфор, кали (N,P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Судалгааны үр дүнг хүснэгт -17 болон доорх зургаас харахад хөрсний хөдөлгөөнт фосфор P<sub>2</sub>O<sub>5</sub>-ын агууламж судалгааны талбайн хөрсний бүх дээжинд илэрсэн мөгөөд 0.6-2.7 мг/100г буюу багаас сайн хангамжтай байна.



**Зураг 82. Хөрсний хөдөлгөөнт фосфор**

Доорх зургаас харахад хөрсөнд дэх хөдөлгөөнт калийн хувьд мөн адил судалгааны талбайн хөрсний бүх дээжинд илэрсэн бөгөөд 23-80 мг/100г буюу маш сайн хангамжтай байна.




**Зураг 83. Хөрсний хөдөлгөөнт кали**

### 1.17.5 Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 1-0.05мм, тоосных 0.05-0.001 мм,

шаврынх  $<0.001$  мм тус тус байдаг. Хөрсний механик бүрэлдэхүүн нь чийг багтаамж, нэвчилтийн эрчим, органик бус шим тэжээлийн бодисын хангамж, нягтшил зэрэг олон үзүүлэлтэд маш нөлөөтэй байдаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг.



**Зураг 84. Хөрсний механик бүрэлдэхүүн**

Нийт 11 хөрсний дээжин дэх механик бүрэлдэхүүний харьцааг дээр зурагт харууллаа. Нийт дээжинд байгаа элсэн фракци 45-79%, тоосны фракци 11-39%, физик шаврын агууламж 2.6-15.4% тус тус эзэлж байна. Шаврын агууламж маш бага харин элсэн фракци дийлэнх хувийг эзэлж байгаа тул эдгээр хөрс нь бүгд элсэнцэр болон элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй хөрс байна.

**Хүснэгт 18. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүн буюу механик бүрэлдэхүүн**

№	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	$<0.001$	$<0.01$
1	YFW-1	-	25.2	53.6	1.9	4.1	4.7	10.3	19.2
2	Yangir West-2	0-20	35.3	42.1	7.5	1.7	10.1	3.2	15.1
3		20-30	32.1	39.8	10.5	0.7	10.5	6.3	17.5
4	Мод үржүүлэг	0-10	29.6	47.2	3.6	3.2	8.3	8.1	19.6
5	BSW-1S	0-10	15.9	59.0	8.8	5.7	6.1	4.4	16.2
6	Т/О талбай	0-8	10.5	59.2	8.0	3.4	7.7	11.2	22.3
7		8-30	8.7	36.5	17.7	9.0	12.6	15.4	37.0

8	Big Slope-7	0-22	19.8	57.6	5.5	6.1	3.9	7.1	17.1
9		22-40	20.0	51.4	10.2	6.7	5.5	6.3	18.4
10	BlueBill-1S	0-30	37.0	42.3	8.8	2.5	6.7	2.6	11.8
11	Номгон - 10	0-10	37.0	42.3	8.8	2.5	6.7	2.6	11.8

### 1.17.6 Хөрсний бохирдол

“Номгон IX” хайгуулын болон туршилт олборлолтын талбайгаас нийт 10 цэгээс хүнд элементийн дээжлэлт хийлээ. Тухайн талбай нь хүний нөлөөлөлд их бага хэмжээгээр өртсөн байна. Тиймээс тухайн цэгийн бохирдуулж болзошгүй эх үүсвэрүүд болон байгалийн унаган төрхөө хадгалж буй газруудаас хяналт, харьцуулалтын цэг болгон дээжлэлтүүдийг хийсэн.


Байгаль дээр түгээмэл тархдаг хүнд металлууд болох никель, кадмий, хар тугалга, зэс, цайр, хромын агууламжийг “Инженер геодези” ХХК-ий Хөрс-Агрохимийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Үр дүнгээс харахад кадмий бүх цэгт огт илрээгүй байна. Бусад металлын агууламжийг MNS 5850:2019 стандартын хүлцэх агууламжтай харьцуулж үзлээ Никелийн агууламж 29.8-45.2 мг/кг буюу стандартаас 3-5 дахин бага байна. Хар тугалга 15.2-25.5 мг/кг буюу стандартаас 4-6 дахин бага байна. Зэсийн агууламж 22.8-49.4 мг/кг буюу стандартаас 2-5 дахин бага байна. Цайрын агууламж 51.6-71.6 мг/кг буюу стандартаас 4-6 дахин бага байна. Хромын агууламж 5.6-15.6 мг/кг буюу стандартаас даруй 10-30 дахин бага дүнтэй гарсан байна. Тухайн дээжлэлт хийсэн газруудад хүнд металлын бохирдол илрээгүй буюу бохирдолгүй байна.

### Хүснэгт 19. Хөрсний хүнд металлын агууламж

№	Дээжний нэр	Хүнд металл мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	YFW-1	29.8	ND	16.1	22.8	51.6	ND
2	Yangir West-2	31.4	ND	16.7	24.4	55.2	10.6
3	Big Slope-Shallow-1	33.2	ND	18.3	27.0	71.6	11.5
4	BSW-1S	38.1	ND	19.2	27.7	63.7	5.59
5	ТО талбай	36.4	ND	16.2	28.0	60.8	15.6
6	Big Slope-7	34.3	ND	16.9	24.3	59.5	10.2
7	BlueBill-1S	44.7	ND	25.5	49.4	61.8	9.51
8	Номгон-10	41.6	ND	15.2	25.9	71.2	8.36
9	Номгон-9	45.2	ND	21.6	37.3	59.2	9.40
10	Номгон-8	39.2	ND	16.3	35.5	51.6	12.8

Хүлцэх агууламж /MNS 5850:2019/	150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/	1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/	1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0


Доорх зургаас харахад никелийн агууламж хүлцэх агууламжаас 3-5 дахин бага буюу бохирдолтгүй байна.



**Зураг 85. Хөрсөн дэх никель Ni -ийн агууламж**


Доорх зургаас харахад хар тугалгын агууламж хүлцэх агууламжаас дариу 4-6 дахин бага буюу бохирдолтгүй байна.






**Зураг 86. Хөрсөн дэх хар тугалга Pb -ын агууламж**

Доорх зургаас харахад зэсийн агууламж хүлцэх агууламжаас дариу 2-4 дахин бага буюу бохирдолтгүй байна.



**Зураг 87. Хөрсөн дэх зэс Cu -ийн агууламж**

Доорх зургаас харахад цайрын агууламж хүлцэх агууламжаас дариу 3-5 дахин бага буюу бохирдолтгүй байна.



**Зураг 88. Хөрсөн дэх цайр Zn -ын агууламж**

### **1.17.7 Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт**

Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт нь тухайн хөрсөн бүрхэвч эрүүл ахуйн хувьд шаардлагад нийцэж буй эсэх, ямар нэгэн дам нөлөөгөөр хөрсөн бүрхэвчид нянгийн бохирдол үүссэн эсэхийг хянахад чухал үүрэгтэй юм.

Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлтийг туршилт, олборлолтын талбайн кемп, хогийн цэг, цэвэрлэх байгууламж, номгон-8 цооног болон нүхэн жорлон гэх 4 цэгээс авсан. Лабораторийн шинжилгээгээр нянгийн тоо, E.coli, Salmonella, Cl.perfringens гэх 4 үзүүлэлтийг шинжлүүлсэн.

**Хүснэгт 20. Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт**

Дээжний нэр	Нянгийн тоо	Гэдэсний савханцар		
		E.coli	Salmonella	Cl.perfringens
Кемп	$7.5 \cdot 10^6$	Цэвэр	Цэвэр	Цэвэр
Нүхэн жорлон	$2 \cdot 10^5$	Цэвэр	Цэвэр	Цэвэр
Цэвэрлэх байгууламж	$8.5 \cdot 10^5$	Цэвэр	Цэвэр	Цэвэр
Хогийн цэг	$2.5 \cdot 10^5$	Цэвэр	Цэвэр	Цэвэр
Номгон-8	$9.5 \cdot 10^5$	Цэвэр	Цэвэр	Цэвэр

### **1.17.8 Дүгнэлт**

“Номгон IX” талбайд 2 өдрийн турш хээрийн судалгааг хийж гүйцэтгэлээ. Хээрийн судалгааны үеэр 4 удаагийн хөрсний зүсэлт хийж ерөнхий хими, физикийн 11, хүнд металлын 10, эрүүл ахуйн 5 дээжийг лабораторийн задлан шинжилгээнд зориулан авсан. Тухайн талбайн ялзмагийн агууламж 0.19-1.59% хувьтай гарсан бөгөөд бага болон маш бага ялзмагийн агууламжтай байна. Урвалын орчин бүх цэг дээр хүчтэй болон маш хүчтэй шүлтлэг орчинг үзүүлж байна. Цахилгаан дамжуулах чадвар туршилт, олборлолтийн талбайн цэгийн өнгөн хөрсөнд 4.23 dS/m буюу их давсархаг, гүний дээжинд 8.79 dS/m буюу хэт их давсархаг байна. Yangir West-2 цэгийн өнгөн хөрсөнд 3.31 dS/m буюу дунд зэрэг давсархаг, гүний дээжинд 1.39 dS/m буюу сул давсархаг байна. Мод үржүүлгийн талбай, Yangir Far West-1 цэг дээр 0.75 dS/m гарсан нь сул давсархаг орчинг үзүүлж байна. Бусад цэгүүд давсжилтгүй байгаа нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.


Хөрсний хүнд металлын бохирдлын хувьд бүх дээж бохирдолгүй буюу зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дүн байхгүй. Эрүүл ахуйн үзүүлэлт буюу нянгийн шинжилгээгээр бүх цэгт мөн адил бохирдолгүй гарсан байна.

### **1.18 Ургамлын орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

Ургамлын хяналт шинжилгээний ажил нь төсөл хэрэгжүүлэгчийн 2023 оны батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний ургамлын хяналт шинжилгээнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд төслийн туршилт олборлолтын талбай болон өрөмдлөг хайгуулын цооногуудын ургамлан нөмрөгийн өнөөгийн суурь нөхцөл байдлыг тодорхойлох, хайгуулын үйл ажиллагаанаас ургамлын нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөллийг хянахад энэхүү судалгааны гол зорилго оршино.

Бүтэгдэхүүн хуваах гэрээт “Номгон IX” талбайн ургамлын мониторинг судалгааг 2023 оны 10 сарын 7-10 ны хооронд хийж гүйцэтгэлээ “Жи Өү Эйч” ХХК нь Номгон IX талбайд 2023 онд 7 цэгт хайгуулын өрөмдлөг хийсэн байна. Эдгээр цэгүүдийг төлөөлүүлэн ургамлын мониторинг судалгааг хэрэгжүүлэв.

Бидний судалгааны талбай болох “Номгон IX” талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Голарктикийн их муж Евроазийн мужийн Алашаа болон Говь – Алтайн уулын цөлөрхөг хээр, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргуудын хил залгаа бүс нутагт байрлаж байна.



**Зураг 89. Төслийн талбайн ургамал газарзүйн байршил**

Тухайн тойргуудын үндсэн төрхийг илэрхийлэгч ургамлуудаас дурдвал Монгол хойрго (*Potania mongolica*), Монгол буйлс (*Amugdalus mongolica*), Монгол мөнххаргана (*Ammoriptanyhus mongolicus*), Монгол буурцгана (*Chesneya mongolica*), Монгол шардалан (*Tugarinovia mongolica*), Тоорой (*Populus diversifolia*), Зүүнгарын улаанбударган (*Reaumurai soongorica*), Говийн хялгана (*stipa gobica*), Сайрын хялгана (*Stipa glaerosa*), Паульсын бударгана (*Salsola paulsenii*), Каспийн шарбударгана (*Kalidium gracile*), хамхуул (*Corispermum mongolicum*), үслиг мананхамхаг (*Bassia dasphylla*), шар бударгана (*Kalidium gracile*), Потанины хотир (*Zygophyllum potaninii*), Цагаан модот заг (*Haloxylon ammodendron*), Толгодын бударгана (*Salsola passerina*), Шивүүрт эмгэншилбэ (*Atraphaxis spinosa*), Рагелийн шар мод (*Sympegma regelii*), Шар хотир (*Zygophyllum xanthoxylon*), Роборовскийн хармаг (*Nitraria roborowskii*), Потанины улаантулам (*Incarvillea potaninii*), Павловын хунчир (*Astragalus pawlovii*), Муркрофтын жигд (*Elaeagnus moorcroftii*) зэрэг ургамлуудыг дурдаж болно. Энэ тойргийн гол онцлог нь унаган, үлдвэр ургамлын төрөл зүйлүүд олон байдгаараа бусад бүс нутаг болон ургамалжилтын тойргуудаас ихээхэн ялгаатай юм.

### **1.18.1 Судалгааны аргазүй**

Ургамлан нөмрөгийн мониторинг судалгааг хийхдээ тухайн бүс нутагт өмнө нь хийгдэж байсан судалгаа шинжилгээний материал ном зохиолтой танилцах буюу бэлтгэл үе шат, тухайн бүс нутагтай газар дээр нь очиж танилцах буюу хээрийн хэмжилт судалгааны үе шат, цуглуулсан мэдээ материал болон хээрийн судалгааны тоо баримтыг боловсруулах буюу боловсруулалтын үе шат гэсэн үндсэн гурван үе шатад хуваан хэрэгжүүллээ.

**Номзүйн судалгаа:** Төслийн талбайн номзүйн судалгааны хүрээнд 2019 онд хийсэн “Жи Өү Эйч” ХХК-ний Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Цогтцэций, Цогт-Овоо, Номгон, Манлай сумдын нутагт хэрэгжих бүтээгдэхүүн хуваах гэрээт “Номгон-IX” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд “Нүүрсний давхаргын метан хийн хайгуул судалгааны ажил гүйцэтгэх” төслийн байгаль орчны төлөв байдал болон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангууд, жил бүрийн БОМТ хэрэгжилтийн тайлангуудтай танилцаж зарим үр дүн болон тоон үзүүлэлтийг тайланд ашиглав.

**Хээрийн судалгааны арга:** Ургамлын бүрхэц, хучилтын хэмжээг тогтоохдоо геоботаникийн арга болох  $1 \times 1 \text{ м}^2$  талбайн ургамлын бүрхцийг нүдэн баримжааны аргаар тодорхойлж, бичиглэл хийсэн ба  $1 \text{ м}^2$  талбай дах бодгалийн тоог гаргахдаа жижиг үет ургамлыг дэгнүүлийн тоогоор, бут сөөглөг ургамлыг  $10 \times 10 \text{ м}^2$  талбайд бут сөөгийг тоолох аргаар, ургамлын биомассыг хэмжихдээ нойтон ургацыг газар дээр нь жингийн аргаар тодорхойлсон.

**Зураглалын арга:** Төслийн талбайн ургамалжилтын тархац, бүлгэмдлийн хил хязгаарыг тогтоохдоо “GPS” -ээр цэгийг тодорхойлж, ургамалжилтын өнгө газрын гадарга уул толгодоор баримжаалан “google” болон Монгол орны ургамалжилтын зураг, өндрийн тоон загвар, 1:100000 масштабтай байр зүйн зургуудыг давхцуулан түүнд тэмдэглэл хийж, ажиглалт хэмжилтийн цэг бүрээр зургийн тайлалыг гарган ургамалжилтын зураг зохиов. Зураглалыг “ArcGIS” буюу газарзүйн мэдээллийн системийн программ хангамжуудийг ашигласан.

### **1.18.2 Мониторинг судалгааны үр дүн**

“Номгон IX” талбайн 2023 оны хайгуулын өрөмдлөг судалгааны ажил нь Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт 6 цэгт, Баян – Овоо сумын нутагт 1 цэгт хийгдсэн байна. Хайгуул судалгааны ажил хийгдсэн нутаг нь ургамал газарзүйн тойргийн хувьд Алашаа говийн тойрогт хамаарагдах бөгөөд энд ургамлан нөмрөгийн хувьд хэт гандуу говийн сөөг, сөөглөг ургамал зонхилсон ургамлан нөмрөгтэй бөгөөд нам хотос өргөн хөндийгөөр гол төлөв бударгана зонхилсон ургамлан нөмрөг тохиолдох бол уулын хажуу бэлээр бударгана – баглуурт, таана – баглуурт бүлгэмдлүүд тохиолдох бол өндөр уулаар таана – хялганат, таана –

хядгана – баглуурт гэсэн ургамлан бүлгэмдлүүд түлхүү тохиолдоно. Алашаа говийн тойрог нь газарзүй уур амьсгалын эрс тэс нөлөөнөөс хамаарч нам бэсрэг уулс, хотос хоолой нь өөр өөрийн өвөрмөц ургамлын аймгийг бүрдүүлдэг боловч зүйлийн хувьд цөөн, бүрхэц сийрэг байдаг онцлогтой. Ерөнхийдөө Төв Азийн цөлийн хуурайсаг ургамал зонхилж сөөгөнцөр дэгнүүлт жижиг үетэн давамгайлна. Энд элсэнцэр бор хөрснөөс гадна чулуурхаг бор хөрс нилээд их тааралдана. Бор бударгана, баглуур, хойрго, хотир, шар мод, боролзой, улаанбударгана, заг, хармаг зэрэг ургамлууд зонхилогч болон дэд зонхилогчоор солигдоно.

### **1.18.3 Yangir Far West-1 цооног орчмын ургамлын бичиглэл**

Номгон IX талбайн 2023 оны хайгуулын цооног болох Yangir Far West-1 өрмийн цэг орчимд говь цөлийн өргөн хөндий, хотос хэсгийг дагаж түлхүү тохиолддог сөөг – бударганат ургамлан бүлгэмдэлтэй бөгөөд ургамлын тусгаг бүрхэц 15 – 20 %, 10 м<sup>2</sup> талбайд 5-7 зүйл ургамал тохиолдоно. Тухайн орчинд Бор бударгана *Salsola passerina*, навчархаг бударгана *Kalidium foliatum* (Pall.) Moq., Сибирь хармаг *Nitraria sibirica* Pall., зэрэг ургамлын төрөл зүйлүүд зонхилогч болон дэд зонхилогчоор тохиолдоно. Харин дагалдах зүйлээр Сайрын хялгана - *Stipa glareosa*, Таана - *Allium polyrrhizum*, Аалзны хуш өвс - *Halogeton arachnoideus*, Өргөст бударгана - *Salsola tragus*, Манан хамхаг - *Bassia dasyphylla* (Ficsh. et Mey.), Хөмөл - *Allium mongolicum*, зэрэг ургамлууд түлхүү тохиолдож байв. Ургамлын дундаж өндөр 30-40 см байна.

**Байршил:** Өмнөговь аймаг, Номгон сум, **N:** 42° 52' 12.33", **E:** 105° 06' 02.42"

**Бичиглэлийн дугаар:** Yangir Far West-1



**Гадаргын байдал:** Уудам тал хөндий, газрын гадарга тэгшэвтэр, хармагийн довонгуудтай.

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээр

**Чийгийн хангамж:** Атмосферийн

**Бэлчээрийн усан хангамж:** Гүний

**Талхлагдлын зэрэг:** Талхлагдаагүй

**Тусгаг бүрхэц:** 15 – 20 %

Буурцагтан-0%, үетэн-5%, улалж 5-%, алаг өвс 10%, шарилж-0%, сонгинлог-10% байна.



**Үелэл, өндөр:** II 20-30 см

Борог, хагд өвсний хуримтлал: 0%

**Бүлгэмдэл:** Сөөг – Бударганат

**Бэлчээр ашиглалтын төрөл:** Зун, хаврын бэлчээр

**Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:**

- Бор бударгана /*Salsola passerina*/
- Бударгана /*Kalidium foliatum* /
- Хармаа /*Nitraria sibirica* Pall./

**Биомасс:** 2023 оны 10 сарын эхээр 1 м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац - 40.9 гр, хуурай ургац - 13.52 гр буюу 1.3 ц/га бэлчээрийн ургацтай байна.

#### Хүснэгт 21. YFW-1цэгийн ургамлын бичиглэл

№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Salsola passerina</i> .	15	cop1	20-30	Ургал бие
2	<i>Kalidium foliatum</i> (Pall.) Moq.	5-10	sol	20-25	Ургал бие
3	<i>Nitraria sibirica</i> Pall.	2-3	sol	20-25	Ургал бие
4	<i>Stipa glareosa</i>	1	sol, sp	10	Ургал бие
Ойр орчимд					
5	<i>Allium polyrrhizum</i>	1	Sp	6	Ургал бие
6	<i>Halogeton arachnoideus</i>	>1	sol	12	Ургал бие
7	<i>Salsola tragus</i>	>1	sol	15	Ургал бие
8	<i>Bassia dasyphylla</i> (Ficsh. et Mey.)	>1	rr	10	Ургал бие
9	<i>Allium mongolicum</i>	>1	sol	12	Ургал бие

#### **1.18.4 Blue bill-1S цооног орчмын ургамлын бичиглэл**

Blue bill-1S цэг нь цөлийн Үетэн – Сөөгт ургамлан бүлгэмдэлтэй бөгөөд ургамлын тусгаг бүрхэц 20-30%, 1 м<sup>2</sup> талбайд 5 зүйл ургамал тохиолдох бол ойр орчимд 7 – 9 зүйл ургамал тохиолдож байна. Тухайн орчинд Шар мод *Sympegma regelii* Bge., Манан хамхаг *Bassia dasyphylla* (Fisch. et Mey.), үет ургамлаас Гейманы бөөдий *Aristida Heymannii* Rgl., Говийн хялгана *Stipa gobica* Roshev., Бага хургалж *Eragrostis minor* Host түлрүү тохиолдох бол дагалдах зүйлээр Шар модот хотир *Zygophyllum xanthoxylon* (Bge.), Хөмөл *Allium mongolicum*, Лууль *Chenopodium album* L., Шинэсэрхүү бударгана *Salsola laricifolia* Turcz., Зэлэн зангуу *Tribulus terrestris* L., зэрэг ургамлууд түлхүү тохиолдож байна. Ургамлын дундаж өндөр 20-30 см байна.

**Байршил:** Өмнөговь, Баян - Овоо сум **N:** 42° 53' 02.74", **E:** 105° 41' 43.67"

**Бичиглэлийн дугаар:** Bluebill-1S(Re)



**Гадаргын байдал:** Аараг толгодын дундах нарийн хөндий, сайр

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээр

**Чийгийн хангамж:** Атмосферийн

**Бэлчээрийн усан хангамж:** Гүний

**Талхлагдлын зэрэг:** Бага

**Тусгаг бүрхэц:** 20-30%

Буурцагтан-0%, үетэн-0%, улалж 0%, алаг өвс 10%, шарилж-30%, сонгинлог-0% байна.



Үелэл, өндөр: I 10-15 см, II 20-30 см



Борог, хагд өвсний хуримтлал: 0%

Бүлгэмдэл: Үетэн – Сөөгт

Бэлчээр ашиглалтын төрөл: Өвөл, хаврын бэлчээрт тохиромжтой

Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:

- Шар мод /*Sympegma regelii* Bge./
- Манан хамхаг /*Bassia dasyphylla* (Ficsh.)
- Говийн хялгана /*Stipa gobica* Roshev./

Биомасс: 2023 оны 10 сарын эхээр 1 м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац - 45.9 гр, хуурай ургац - 18.2 гр буюу 1.8 ц/га бэлчээрийн ургацтай байна.

#### Хүснэгт 22. Blue bill-1S цэгийн ургамлын бичиглэл

№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Sympegma regelii</i> Bge.	20	cop1	30	Ургал бие
2	<i>Bassia dasyphylla</i> (Ficsh. et Mey.)	8	sp	10	Ургал бие
3	<i>Aristida Heymannii</i> Rgl.	2	sol	8	Ургал бие
4	<i>Stipa gobica</i> Roshev.	2	sp	10	Ургал бие
5	<i>Eragrostis minor</i> Host	1	sol	5	Ургал бие
Ойр орчимд					
6	<i>Zygophyllum xanthoxylon</i> (Bge.)	-	Sp-sol	30-40	Ургал бие
5	<i>Allium mongolicum</i>	-	sol	12	Ургал бие
6	<i>Chenopodium album</i> L.	-	sol	15	Ургал бие
7	<i>Salsola laricifolia</i> Turcz.	-	un	20	Ургал бие
8	<i>Tribulus terrestris</i> L.	-	rr	2-3	Ургал бие

#### 1.18.5 Big Slope-7 цооног орчмын ургамлын бичиглэл

Big Slope-7 цооног нь орчимд таана оролцсон хялгана – баглуурт бүлгэмдэл тохиолдох бөгөөд гол зонхилогчдоос хялгана буюу Монгол өвс *Stipa glareosa* P. Smirn., ахарнавчит баглуур *Anabasis brevifolia* C. A. Mey., Таана түгээмэл тохиолдож байна. Энд ургамлын тусгаг бүрхэц 30 ±5%, 1 м<sup>2</sup> талбайд 4-5 зүйл, 10м<sup>2</sup> талбайл 10-12 зүйл ургамал тохиолдож байна. Дагалдах ургамлын төрөл зүйлүүдээс дурдвал *Cleistogenes songorica* (Roshev.), *Bassia dasyphylla* (Ficsh. et Mey.), *Rheum nanum* Sievers., *Allium mongolicum* Rgl., *Artemisia scoparia* Waldst. et Kit., *Lagochilus ilicifolius* Bge., *Scorzonera capito* Maxim., *Setaria viridis* (L.) P. B., *Haplophyllum dauricum* (L.) G., *Oxytropis aciphylla* Ldb., зэрэг ургамлууд тохиолдож байна. Өвслөг ургамлын дундаж өндөр 8-10 см, сөөг сөөгөнцөр ургамлын дундаж

өндөр 15-20 см байна. Биомасс буюу хуурай ургацын жин  $1\text{м}^2$  талбайд 23.52 гр буюу 2.3 ц/га бэлчээрийн хуурай ургацтай байна.

**Байршил:** Өмнөговь аймаг, Номгон сум **N:** 42° 55' 37.37", **E:** 105° 14' 15.60"

**Бичиглэлийн дугаар:** Big Slope-7



**Гадаргын байдал:** Уул, уул толгодын хажуугийн доод хэсэгт, хойноос урагш 3°-5° налуутай, довонгүй сөөг, сөөгөндөр ургамалтай хэсэгт ургамлын бичиглэл хийв.

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээр

**Чийгийн хангамж:** Атмосферийн

**Бэлчээрийн усан хангамж:** Гүний

**Талхлагдлын зэрэг:** Соргог, цооног орчмын багахан талбай нөлөөлөлд өртсөн байна.

**Хортон мэрэгчийн нөлөө:** Хортон мэрэгчийн нөлөөгүй

**Тусгагийн бүрхэц:**  $30\pm 5\%$



Буурцагтан-0%, үетэн-40%, улалж 0%, алаг өвс 30%, шарилж-10%, сонгинлог-10% байна.

**Үелэл, өндөр:** I -5-10 см, II 20-30 см

Борог, хагд өвсний бүрхэц: 0%

**Бүлгэмдэл:** Таана - хялгана – Баглуурт

**Бэлчээр ашиглалтын төрөл:** Өвөл, хаврын бэлчээр

**Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:**

- Баглуур /*Anabasis brevifolia*/
- Хялгана /*Stipa glareosa P. Smirn.*/
- Таана /*Allium polyrrhizum Turcz. ex*/

**Биомасс:** 2023 оны 10 сарын эхээр 1м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац - 51.92 гр, хуурай ургац - 23.52 гр буюу 2.3 ц/га бэлчээрийн ургацтай байна.

#### Хүснэгт 23. Big Slope-7 цэгийн ургамлын бичиглэл

№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Anabasis brevifolia C. A. Mey.</i>	10-15	cop1	5	Ургал бие
2	<i>Stipa glareosa P. Smirn.</i>	5	cop1-sp	8	Ургал бие
3	<i>Allium polyrrhizum Turcz. ex</i>	3-5	sp	5-8	Ургал бие
4	<i>Cleistogenes songorica (Roshev.)</i>	1-2	sol	10	Ургал бие
5	<i>Bassia dasyphylla (Ficsh. et Mey.)</i>	3	sol	10	ургал бие
Ойр орчимд					
6	<i>Rheum nanum Sievers.</i>	-	-	3-5	Ургал бие
7	<i>Allium mongolicum Rgl.</i>	-	-	9	Ургал бие
8	<i>Artemisia scoparia Waldst. et Kit.</i>	-	-	15	Ургал бие
9	<i>Lagochilus ilicifolius Bge.</i>	-	-	3	Ургал бие
10	<i>Scorzonera capito Maxim.</i>	-	-	5	Ургал бие
11	<i>Setaria viridis (L.) P. B.</i>	-	-	8	Ургал бие
12	<i>Haplophyllum dauricum (L.) G.</i>	-	-	13	Ургал бие
13	<i>Oxytropis aciphylla Ldb.</i>	-	-	10	Ургал бие

#### 1.18.6 Big Slope Shallow-1 цооног орчмын ургамлын бичиглэл

Big Slope Shallow-1 цооног орчмын талбайн нь орог тэсэг оролцсон Хялгана – Баглуурт ургамлан бүлгэмдэлтэй бөгөөд энд ургамлын тусгаг бүрхэц 30 - 35%, 1 м<sup>2</sup> талбайд 4-6 зүйл ургамал тохиолдох бол ойр орчимд нь 10 – 12 зүйл ургамал тохиолдож байна. Тухайн орчинд Ахарнавчит баглуур *Anabasis brevifolia C. A. Mey.*, Хазааргана *Cleistogenes squarrosa*, Хялгана *Stipa Krylovii Roshev* зонхилогч

болон дэд зонхилогчоор тохиолдох бол дагалдах зүйлээр *Eurotia ceratiodes* (L.) C. A., *Bassia dasyphylla* (Fisch. et Mey.), *Panzeria lanata* (L.) Bge., *Allium polyrrhizum* Turcz. Ex, *Setaria viridis* (L.) P. B., *Salsola pestifera* Nels., *Artemisia scoparia* Waldst., *Ennearogon borealis* (Greseb.), *Asparagus gobicus* Ivanova. Ex, тэргүүтэн түгээмэл тохиолдож байна. 10 м<sup>2</sup> талбайд 2-3 ширхэг сөөг сөөгөнцөр буюу сийрэг сөөг ургамал тохиолдож байна. Ургамлын дундаж өндөр 10-15 см, бэлчээрийн талхлагдал болон үлийн цагаан оготно, хортон шавьжийн нөлөөлөл харьцангуй бага байна. Төслийн үйл ажиллагаа буюу хайгуулын цооногийн багахан талбай нөлөөлөлд өртөж ургамлан нөмрөггүй болсон байна. Хээрийн судалгааны үед өрмийн үйл ажиллагаа дууссан өрмийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн маш сайн хийж гүйцэтгэсэн байна.

**Байршил:** Өмнөговь аймаг, Номгон сум **N:** 42° 55' 37.07", **E:** 105° 14' 23.06"

**Бичиглэлийн дугаар:** Big Slope Shallow-1



**Гадаргын байдал:** Уулын хажуугийн доод хэсэгт, уулын ар хажуу 3-5° налуу

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээр

**Чийгийн хангамж:** Атмосферийн

**Бэлчээрийн усан хангамж:** Гүний буюу хадгаар

**Талхлагдлын зэрэг:** Бага зэрэг талхлагдсан, өрмийн цооног орчмын багахан талбай нөлөөлөлд өртөж ургамлан нөмрөггүй болсон байна.

**Тусгагийн бүрхэц:** 30-35 %

Буурцагтан-5%, үетэн-20%, улалж 0%, алаг өвс 20%, шарилж-20%, сонгинлог-20% байна.



**Үелэл, өндөр:** I -5-10 см, II 15-20 см

Борог, хагд өвсний хуримтлал: 0%

**Бүлгэмдэл:** Хялгана – Баглуурт

**Бэлчээр ашиглалтын төрөл:** Хавар, намрын бэлчээр

**Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:**

- Баглуур /*Anabasis brevifolia* C. A. Mey. /

- Хазааргана / *Cleistogenes squarrosa* /
- Хялгана /*Stipa glareosa* P. Smirn./

**Биомасс:** 2023 оны 10 сарын эхэн үед 1м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац - 43.6 гр, хуурай ургац - 22.4 гр буюу 2.2 ц/га бэлчээрийн ургацтай байна.

#### Хүснэгт 24. Big Slope Shallow-1 цэгийн ургамлын бичиглэл

№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Anabasis brevifolia</i> C. A. Mey.	10-15	cop1	8	Ургал бие
2	<i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)	8-10	sol, sp	12	Ургал бие
3	<i>Eurotia ceratiodes</i> (L.) C. A.	5	cop1	10	Ургал бие
4	<i>Stipa glareosa</i> P. Smirn.	1-2	sol, sp	10	Ургал бие
5	<i>Bassia dasyphylla</i> (Ficsh. et Mey.)	2-3	sol, sp	15	Ургал бие
6	<i>Panzeria lanata</i> (L.) Bge.	1-2	un	5-7	Ургал бие
Ойр орчимд					
7	<i>Allium polyrrhizum</i> Turcz. ex	2	sol, sp	13	Ургал бие
8	<i>Setaria viridis</i> (L.) P. B.	-	sol, sp	11	Ургал бие
9	<i>Salsola pestifera</i> Nels.	-	sp	8-10	Ургал бие
10	<i>Artemisia scoparia</i> Waldst.	-	sp	10	Ургал бие
11	<i>Enneapogon borealis</i> (greseb.)	-	rr	5	Ургал бие
12	<i>Asparagus gobicus</i> Ivanova. ex	-	sol	5	Ургал бие

#### 1.18.7 Big Slope West-1S цооног орчмын ургамлын бичиглэл

Big Slope West-1S цооног орчимд говь, цөлийн хялгана - Баглуурт ургамлан бүлгэмдэлтэй бөгөөд ургамлын тусгаг бүрхэц 30 %, 1 м<sup>2</sup> талбайд 6-8 зүйл ургамал тохиолдох бол ойр орчимд 10 – 11 зүйл ургамал тохиолдож байна. Тухайн орчинд таана Ахар навчит баглуур *Anabasis brevifolia* C. A. Mey., Сайрын хялгана *Stipa glareosa* P. Smirn., *Allium polyrrhizum* Turcz. Ex RgL., зэрэг ургамлууд зонхилогч болон дэд зонхилогчоор тохиолдоно. Харин дагалдах зүйлээр *Salsola pestifera* Nels., *Bassia dasyphylla* (Ficsh. et Mey.), *Eragrostis minor* Host, *Micropeplis*

*arachnoidea (Moq.), Aristida Heymannii Rgl., Enneapogon borealis (greseb.) Salsola collina Pall., Chloris virgata Sw., Cleistogenes songorica (Roshev.)*, зэрэг ургамлууд тохиолдож байна. Ургамлын дундаж өндөр 8-15 см, сөөг ургамал 15-20 см байна. Хээрийн мониторинг судалгааны үед өрмийн үйл ажиллагаа дууссан, нөлөөлөлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн байна.

**Байршил:** Өмнөговь аймаг, Номгон сум **N:** 42° 56' 10.12", **E:** 105° 12' 09.57"

**Бичиглэлийн дугаар:** Big Slope West-1S



**Гадаргын байдал:** Аараг толгод, толгодын хажуугийн доод хэсэгт хойноос урагш 3°-5° налуу, сөөг ургамлын довонгуудтай

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээр

**Чийгийн хангамж:** Атмосферийн

**Бэлчээрийн усан хангамж:** Гүний

**Талхлагдлын зэрэг:** Бага зэрэг, өрмийн цооног орчмын багахан талбайн ургамлан нөмрөггүй болсон байна.

**Тусгаг бүрхэц:** 30±5%

Буурцагтан-0%, үетэн-30%, улалж 0%, алаг өвс 20%, шарилж-10%, сонгинлог-30% байна.



**Үелэл, өндөр:** I -8-15 см, II 15-20 см

**Борог, хагд өвсний хуримтлал:** 1-2 %

**Бүлгэмдэл:** Хялгана – Баглуурт

**Бэлчээр ашиглалтын төрөл:** Хаврын бэлчээр

**Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:**

- Баглуур /*Anabasis brevifolia* /
- Хялгана /*Stipa glareosa* P. Smirn./
- Таана /*Allium polyrrhizum*/

**Биомасс:** 2023 оны 10 сарын эхэн үеийн байдлаар 1м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац - 42.04 гр, хуурай ургац - 21.32 гр буюу 2.1 ц/га бэлчээрийн ургацтай байна.

#### Хүснэгт 25. Big Slope West-1S цэгийн ургамлын бичиглэл

№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Anabasis brevifolia</i> C. A. Mey.	10-15	cop1	5	Ургал бие
2	<i>Stipa glareosa</i> P. Smirn.	2-3	sp	8-10	Ургал бие
3	<i>Salsola pestifera</i> Nels.	2	sp	8-10	Ургал бие
4	<i>Bassia dasyphylla</i> (Ficsh. et Mey.)	2	sol	10	Ургал бие
5	<i>Allium polyrrhizum</i> Turcz. Ex RgL.	3	sp	8-10	Ургал бие
6	<i>Eragrostis minor</i> Host	1	sol	6	Ургал бие
Ойр орчимд нь					
7	<i>Micropeplis arachnoidea</i> (Moq.)	-	un	8	Ургал бие
8	<i>Aristida Heymannii</i> Rgl.	-	sol	7	Ургал бие
10	<i>Enneapogon borealis</i> (greseb.)	-	sol	7	Ургал бие
11	<i>Salsola collina</i> Pall.	-	sol	10	Ургал бие
12	<i>Chloris virgata</i> Sw.	-	un	11	Ургал бие
13	<i>Cleistogenes songorica</i> (Roshev.)	-	sol	8	Ургал бие

#### 1.18.8 Yangir West-2 цооног орчмын ургамлын бичиглэл

Yangir West-2 цооног орчимд мөн таана оролцсон хялгана - баглуурт бүлгэмдэлтэй бөгөөд ургамлын тусгаг бүрхэц 15 – 20 %, 1 м<sup>2</sup> талбайд 3 – 4 зүйл ургамал тохиолдох бөгөөд ойр орчимд нь 15 – 17 зүйл ургамал тохиолдож байна. Тухайн орчинд шарилж *Artemisia pectinata* Pall., таана *Allium polyrrhizum* Turcz. Ex RgL., бор бударгана *Salsola passerina* Bge., ахар навчит баглуур *Anabasis brevifolia* C. A. Mey., зэрэг ургамлууд зонхилогч болон дэд зонхилогчоор тохиолдоно. Харин дагалдах зүйлээр *Convolvulus Ammanii* Desr, *Stipa Krylovii* Roshev., *Cleistogenes songorica* (Roshev.), *Carex* sp, *Rheum nanum* Sievers., *Allium mongolicum* Rgl., *Caragana leucophloea* Pojark., *Astragalus miniatus* Bge.,

*Heteropappus hispidus* (Thunbg.) Less., *Scorzonera pseudodivaricata*, *Tribulus terrestris* L. зэрэг ургамлууд тохиолдож байна. Ургамлын дундаж өндөр 5-10 см, сөөг сөөгөнцөр ургамал 10 – 20 см байна.

**Байршил:** Өмнөговь аймаг, Номгон сум **N:** 42° 55' 42.37”, **E:**105° 06' 05.45”

**Бичиглэлийн дугаар:** Yangir West-2



**Гадаргын байдал:** Уулын хажуугийн доод хэсэгт, уулын ар хажуу

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээр

**Чийгийн хангамж:** Атмосферийн

**Бэлчээрийн усан хангамж:** Гүний

**Талхлагдлын зэрэг:** Талхлагдаагүй, хайгуулын цооног орчмын ургамлан нөмрөг талхлагдсан бөгөөд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

**Тусгаг бүрхэц:** 15±5%

Буурцагтан-5%, үетэн-20%, улалж 0%, алаг өвс 30%, шарилж-20%, сонгинлог-30% байна.





**Үелэл, өндөр:** I -5-10 см, II 10-20 см

**Борог, хагд өвсний хуримтлал:** 0%

**Бүлгэмдэл:** Монгол өвс – таана – бударганат, индекс – 148 (ЦХ-I-1-7)

**Бэлчээр ашиглалтын төрөл:** Зун намрын бэлчээр

**Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:**

- Баглуур /*Anabasis brevifolia* C. A. Mey./

- Хялгана /*Stipa glareosa* P. Smirn./
- Таана /*Allium polyrrhizum* /

**Биомасс:** 2023 оны 10 сарын эхэн үед тухайн орчны 1м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац – 35.92 гр, хуурай ургац - 13.48 гр буюу 1.3 ц/га ургацтай байна.

#### Хүснэгт 26. Yangir West-2 цэгийн ургамлын бичиглэл

№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Anabasis brevifolia</i> C. A. Mey.	8	sp	5-7	Ургал бие
2	<i>Allium polyrrhizum</i> Turcz. Ex Rgl.	3	cop1	8-10	Ургал бие
3	<i>Stipa glareosa</i> P. Smirn.	4	sol	10	Ургал бие
4	<i>Cleistogenes songorica</i> (Roshev.)	2	sp	5	Ургал бие
Ойр орчимд					
5	<i>Artemisia scoparia</i> Waldst.	-	Sol	10	Ургал бие
8	<i>Bassia dasyphylla</i> Ficsh.	-	sol	12	Ургал бие
9	<i>Convolvulus Ammanii</i> Desr	-	sol	5	Ургал бие
10	<i>Allium mongolicum</i> Rgl.	-	sol	8-10	Ургал бие
11	<i>Salsola pestifera</i> Nels.	-	sol	8	Ургал бие
12	<i>Oxytropis aciphylla</i> Ldb.	-	un	6	Ургал бие
13	<i>Lagochilus ilicifolius</i> Bge.	-	rr	13	Ургал бие
14	<i>Dontostemon senilis</i> Maxim.	-	un	5	Ургал бие

#### 1.18.9 Туршилт олборлолтын талбай болон Номгон -10 цооног орчим

Номгон – 10 болон Туршилт олборлолтын талбай нь Өмнөговь аймгийн Номгон сумын Эмгэн булаг багийн нутагт Их өвгөн уулын өвөрт орших бөгөөд сумын төвөөс зүүн хойш 26 км зайд оршино. Биднийг хээрийн судалгаа хийх үед Номгон – 10 цоонгийг туршилт олборлолтын талбайл өрөмждөж дууссан байв. Тухайн талбай нь сайр жалгаар хэрчэгдсэн уулын өвөр, хормойд байрлах бөгөөд өндөрлөг дэнж хэсгийн хөх хайрга чулуун хучаастай хэсгээр маш сийрэг баглуурт ургамлан нөмрөгтэй байхад нарийн судаг сайр жалга дагуу улаан бударгана, бор бударгана зонхилсон бударганат бүлгэмдэлтэй байна. Зарим газраар

бүлгэмдэлд хармаг оролцож хармаг – бударганат бүлгэмдлийг үүсгэнэ. Тухайн орчны ургамлөн нөмрөгийг төлөөлүүлэн туршилт олборлолтын талбайн хашааны гадна талд ургамлын бичиглэл хийсэн. Энд ургамлын тусгагын бүрхэц 15 – 20 %, дагалдах зүйлээр *Anabasis brevifolia*, *Stipa glareosa P.*, *Nitraria sibirica*, *Salsola laricifolia*, *Iris Bungei Maxim*, *Eragrostis minor Host*, *Astragalus laguroides Pall.*, *Zygophyllum Xanthoxylon*, *Rheum nanum*, зэрэг ургамлууд маш сийрэг тохиолдоно. Энд 1 м<sup>2</sup> талбайд 2-4 зүйл ургамал тохиолдох бол 10 м<sup>2</sup> талбайд 6 – 8 зүйл ургамал тохиолдож байна.

**Байршил:** Өмнөговь аймаг, Номгон сум, **N:** 42°52'15.49” **E:**105° 28' 15.49”

**Бичиглэлийн дугаар:** Номгон- 10 -р цооног болон туршилт олборлолтын талбай



**Гадаргын байдал:** Өнөдөр уул, уулын өмнөд хажуугийн доод хэсэгт, газрын гадарга хойноос урагш 3-5 хэмийн налуу,

**Газар ашиглалтын байдал:** Бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байсан бөгөөд одоо 3 га талбайг туршилт олборлолтын зориулалтаар ашиглагдаж байна.

**Чийгийн хангамж:** Атмосферийн буюу хур борооны усаар

**Усан хангамж:** Гүний

**Талхлагдлын зэрэг:** Бэлчээрийн талхлагдал бага

**Нөлөөлөл:** Туршилт олборлолтын 3 га талбайн ургамлан нөмрөг талхлагдаж халцгайрсан, машин техникийн нөлөөлөлд өртсөн байна.

**Тусгагийн бүрхэц:** 10 – 15 %

Буурцагтан – 1 %, үетэн-15 %, улалж 0%, алаг өвс 10%, шарилж – 5 %, сонгинлог-10% байна.



**Үелэл, өндөр:** I: 5 – 10 см, Сөөг: 10 – 15 см

**Борог, хагд өвсний хуримтлал:** 0%

**Бүлгэмдэл:** Хармаг – Бударганат бүлгэмдэл

**Гол зонхилогч өнгө үүсгэгч ургамал:**


- Улаанбударгана /*Reaumuria soongorica* (Pall.)/
- Бор Бударгана /*Salsola passerina* /

**Биомасс:** 2023 оны 10 сарын эхэн үед 1м<sup>2</sup> талбайн чийгтэй ургац - 20.3 гр, хуурай ургац - 11.2 гр буюу 1.1 ц/га бэлчээрийн ургацтай байна.

#### Хүснэгт 27. Туршилт олборлолтын талбай орчмын ургамлын бичиглэл


№	Ургамлын нэр	Бүрхэц, %	Арви	Өндөр, см	Хөгжлийн үе шат
1	<i>Salsola passerina</i>	8	Cop1-Sp	15	Ургал бие
2	<i>Reaumuria soongorica</i> (Pall.)	6	Cop1-Sp		Ургал бие
3	<i>Anabasis brevifolia</i>	1-2	sp	4	Ургал бие
4	<i>Stipa glareosa</i> P.	1	sp	8	Ургал бие
Ойр орчимд нь					
5	<i>Nitraria sibirica</i>	-	Sp	20	Ургал бие
6	<i>Salsola laricifolia</i>	-	sol	20	Ургал бие
7	<i>Iris Bungei</i> Maxim	-	rr	15	Ургал бие
8	<i>Eragrostis minor</i> Host	-	sol	5	Ургал бие
9	<i>Astragalus laguroides</i> Pall.	-	rr		Ургал бие
10	<i>Zygophyllum Xanthoxylon</i>	-	sp	30-40	Ургал бие
11	<i>Rheum nanum</i>	-	sol	4	Ургал бие

Номгон – 9 талбайн 2023 оны хайгуул судалгааны хүрээнд хийгдсэн 7 өрмийн цооног орчмын ургамал нөмрөгийн өнөөгийн төлөв байдал болон хайгуул судалгааны нөлөөллийг хянах үүднээс өрмийн цэг бүрд ургамлын бичиглэл хийсэн бөгөөд эдгээр бичиглэл хийсэн цэгүүдийн ургамлын тусгагын бүрхцийг харьцуулан үзвэл 10 – 35 % ийн хооронд байна. Доорх зургаас харахад Номгон – 10 цооног буюу туршилт олборлолтын талбай орчмын ургамлан нөмрөг хамгийн сийрэг ургамалтай буюу ургамлын бүрхэц 10 % байхад Big slope – 7 цооног орчимд ургамлын бүрхэц хамгийн сайн буюу 35 % -ийн бүрхэцтэй байна. Мониторинг судалгаа хэрэгжүүлэн 7 цэгийн бүрхцийг дундажлан үзвэл 23 % байгаа ургамлын бүрхэц бага байсныг илтгэж байна.




**Зураг 90. Мониторингийн цэгүүдийн ургамлын бүрхэц**

Мониторинг судалгаа хэрэгжүүлсэн 7 цэгийн ургамлын биомассыг харьцуулан үзвэл Номгон 10 -р цооног болон туршилт олборлолтын талбайн орчимд хамгийн бага буюу 1.1 ц/га ургацтай байхад Big slope – 7, Big slope shallow – 1 цооног орчимд хамгийн их буюу ургац 2.2 - 2.3 ц/га ургацтай байна. Тухайн 7 цэгийн ургацын хэмжээг дундажлан авч үзвэл 1.7 ц/га буюу бүс нутгийн дунджаас бага бэлчээрийн ургацтай байна.




**Зураг 91. Мониторингийн цэгүүдийн ургац буюу биомасс**



**Зураг 92. Төслийн талбайн 2021 он болон 2022 оны NDVI –ийн харьцуулсан зураг**

Ургамлын нормчлогдсон ялгаврын индексийг сүүлийн 3 жилээр буюу 2021-2023 оны зураглалыг хийж үзэхэд NDVI утга хамгийн ихдээ 2021 онд 0.49 байхад 2022 онд 0.45, 2023 онд 0.48 байна. Харин хамгийн бага утга нь -0.21 – 26 хооронд буюу огт ургамал нөмрөггүй байна. Ургамлын нормчлогдсон ялгаврын индексийн зургаас харахад төслийн талбайн зүүн хойд хэсгээр буюу Манлай сумын нутаг орчмоор ургамлын гарц харьцангуй сайн байдаг бол төслийн талбайн баруун өмнөд хэсэг буюу Номгон, Баян – Овоо сумдын нутгаар ургамлын гарц маш буу байдаг нь зураглалаас харагдаж байна. Төслийн талбайн хойд болон зүүн хойд хэсгээр цөлөрхөг хээрийн хэв шинжтэй сөөг – үетэнт ургамал бүлгэмдэлтэй байдаг бол төслийн талбайн өмнөд хэсгээр хэт гандуу цөлийн хэв шинжтэй буюу маш сийрэг сөөгт ургамал нөмрөгтэй байдаг онцлогтой. Сүүлийн жилүүдэд төслийн талбайн өмнөд хэсэг болох Номгон, Баян - Овоо сумдын зарим нутгаар

маш их хуурайшилттай гантай байгаа нь зургаас харагдаж байна.



**Зураг 93. Төслийн талбайн 2023 оны NDVI –ийн зураглал**

### 1.18.10 Ургамлын мониторинг судалгааны дүгнэлт

“Жи Өү Эйч” ХХК –ийн Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян – Овоо, Ханхонгор, Ханбогд, Цогт – Овоо, Номгон, Манлай сумдын нутагт хэрэгжиж буй бүтээгдэхүүн хуваах гэрээт “Номгон – IX” хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн Нүүрсний давхаргын метан хийн хайгуул судалгааны хүрээнд 2023 онд нийт 7 цэгт хайгуулын өрөмдлөг хийсэн байна. Үүнээс 1 нь Баян – Овоо сумын нутагт, 6 нь Номгон сумын нутагт гүйцэтгэсэн байна. Бид ургамлын мониторинг судалгааг намар 10 сард 1 удаа гүйцэтгэсэн бөгөөд ургамлын мониторинг судалгааг өрөмдлөгийн 7 цооног орчмын ургамал нөмрөгийг төлөөлүүлэн гүйцэтгэлээ.

Эдгээр цэгүүдийн орчимд сөөг – бударганат, үетэн – Сөөгт, таана оролцсон хялгана – баглуурт, бударганат ургамал бүлгэмдлүүд тохиолдох бөгөөд тухайн ургамал бүлгэмдлүүдэд ургамлын тусгагийн бүрхэц 10 - 35 %, өвслөг ургамлын дундаж өндөр 8-10 см, сөөг, сөөгөнцөр ургамлын дундаж өндөр 15 – 35 см байна. Ургамлан нөмрөгт үзүүлсэн талхлагдал нөлөөлөл харьцангуй бага бөгөөд өрмийн цэгт ойролцоогоор 5-7 метрийн радиустай талбайн ургамлан

нөмрөг талхлагдаж халцгайрсан бол туршилт олборлолтын цооногийн 3 га талбайн ургамал нөмрөг нөлөөлөлд өртсөн байна.

Мониторинг судалгаа хэрэгжүүлсэн 7 цэгийн ургамлын биомассыг харьцуулан үзвэл Номгон 10 -р цооног болон туршилт олборлолтын талбайн орчимд хамгийн бага буюу 1.1 ц/га ургацтай байхад Big slope – 7, Big slope shallow – 1 цооног орчимд хамгийн их буюу ургац 2.2 - 2.3 ц/га ургацтай байна. Тухайн 7 цэгийн ургацын хэмжээг дундажлан авч үзвэл 1.7 ц/га буюу бүс нутгийн дунджаас бага бэлчээрийн ургацтай байна.

Ургамлын нормчлогдсон ялгаврын индексийг сүүлийн 3 жилээр буюу 2021-2023 оны зураглалыг хийж үзэхэд NDVI утга хамгийн ихдээ 2021 онд 0.49 байхад 2022 онд 0.45, 2023 онд 0.48 байна. Харин хамгийн бага утга нь -0.21 – 26 хооронд буюу огт ургамал нөмрөггүй байна. Ургамлын нормчлогдсон ялгаврын индексээс үзэхэд төслийн талбайн зүүн хойд хэсгээр ургамлын гарц харьцангуй сайн өмнөд хэсгээр маш тааруу байгаа нь ажиглагдаж байна.

Цаашид ургамлын мониторинг судалгааг тогтмол нэг цаг хугацаанд хийх нь зүйтэй бөгөөд тухайн бүс нутагт 8 сарын 15 -аас 9 сарын 10 ны хооронд ургамлын мониторинг судалгааг хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй бөгөөд тохиромжтой байдаг.

### **1.19 Усны чанарын орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

Усны мониторинг судалгаагаар 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 3 уст цэгээс дээж авч Инженер геодези ХХК-ийн лабораторид шинжилгээнд хамруулж усны химийн үзүүлэлтийг тодорхойлуулсан.



**Зураг 94. Мод үржүүлгийн талбайгаас усны дээж авч буй байдал**




**Зураг 95. Туршилт олборлолтын талбайгаас усны дээж авч буй байдал**



**Зураг 96. Топ Даймонд Дриллинг ХХК хайгуулын кемпээс усны дээж авч буй байдал**





Зураг 97. 2023 онд усны дээж авсан цэгүүдийн байршил

Хүснэгт 28. Усны шинжилгээний дүн

Анион	1 дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1 дм <sup>3</sup> -д байгаа			Шинжилгээний дүнгийн тайлбар
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%	
<b>Мод үржүүлгийн талбайн ус</b>								
Cl <sup>-</sup>	273.67	7.71	51.60	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	256.07	11.13	74.53	Химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийг эрдэсжилтэй, зөөлөвтөр ус байна.
SO <sub>4</sub> <sup>2-</sup>	157.80	3.29	21.99	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.10	0.01	0.04	
NO <sub>2</sub> <sup>-</sup>	15.14	0.24	1.63	Ca <sup>++</sup>	46.09	2.30	15.40	
NO <sub>3</sub> <sup>-</sup>	0.01	0.00	0.00	Mg <sup>++</sup>	18.24	1.50	10.04	
CO <sub>3</sub> <sup>2-</sup>	6.00	0.10	0.67	Fe <sup>++</sup>	0.00	0.00	0.00	
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	219.67	3.60	24.10	Fe <sup>+++</sup>	0.00	0.00	0.00	
Дүн	672.29	14.94	100.00	Дүн	320.50	14.94	100.00	
<b>Номгон 10</b>								
Cl <sup>-</sup>	129.75	3.65	32.81	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	166.35	7.23	64.94	

Анион	1 дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1 дм <sup>3</sup> -д байгаа			Шинжилгээний дүнгийн тайлбар
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%	
SO <sub>4</sub> <sup>-</sup>	179.60	3.74	33.57	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.10	0.01	0.05	Химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийг эрдэсжилтэй, зөөлөвтөр ус байна.
NO <sub>2</sub> <sup>-</sup>	15.14	0.24	2.19	Ca <sup>++</sup>	44.09	2.20	19.75	
NO <sub>3</sub> <sup>-</sup>	0.00	0.00	0.00	Mg <sup>++</sup>	20.67	1.70	15.26	
CO <sub>3</sub> <sup>-</sup>	6.00	0.10	0.90	Fe <sup>++</sup>	0.00	0.00	0.00	
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	207.47	3.40	30.53	Fe <sup>+++</sup>	0.00	0.00	0.00	
Дүн	537.95	11.14	100.00	Дүн	231.21	11.14	100.00	
<b>Номгон 10</b>								
Cl <sup>-</sup>	779.90	21.97	17.08	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	2823.22	122.75	95.41	Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг их эрдэсжилтэй, хатуу ус байна.
SO <sub>4</sub> <sup>-</sup>	1.12	0.02	0.02	NH <sub>4</sub> <sup>+</sup>	1.50	0.08	0.06	
NO <sub>2</sub> <sup>-</sup>	10.32	0.17	0.13	Ca <sup>++</sup>	66.13	3.30	2.56	
NO <sub>3</sub> <sup>-</sup>	0.00	0.00	0.00	Mg <sup>++</sup>	30.40	2.50	1.94	
CO <sub>3</sub> <sup>-</sup>	6.00	0.10	0.08	Fe <sup>++</sup>	0.20	0.01	0.01	
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	6492.53	106.40	82.70	Fe <sup>+++</sup>	0.30	0.02	0.01	
Дүн	7289.87	128.66	100.00	Дүн	2921.75	128.66	100.00	
<b>Blue bill-1s (Топ Даймонд Дриллинг ХХК хайгуулын кемп)</b>								
Cl <sup>-</sup>	136.13	3.83	34.00	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	185.69	8.07	71.58	Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилтэй, зөөлөвтөр ус байна.
SO <sub>4</sub> <sup>-</sup>	161.60	3.36	29.83	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.10	0.01	0.05	
NO <sub>2</sub> <sup>-</sup>	4.82	0.08	0.69	Ca <sup>++</sup>	36.07	1.80	15.96	
NO <sub>3</sub> <sup>-</sup>	0.10	0.00	0.02	Mg <sup>++</sup>	17.02	1.40	12.41	
CO <sub>3</sub> <sup>-</sup>	0.00	0.00	0.00	Fe <sup>++</sup>	0.00	0.00	0.00	
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	244.08	4.00	35.46	Fe <sup>+++</sup>	0.00	0.00	0.00	
Дүн	546.71	11.28	100.00	Дүн	238.89	11.28	100.00	

## 1.20 Амьтны судалгааны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Монгол оронд ховор аргал, янгир, хар сүүлт, зээр тас, бүргэд гээд тэр болгон тааралдахгүй амьтан шувууд 2021 онд амьтны мониторингийн судалгаа хийж баримтуулсан боловч 2022 оны мониторингийн судалгааны үед Номгон сумын Цагаан толгойн бүтцийн ордын өрөмдлөг, туршилт олборлолтын ойр 5 км орчим

хулан ганц нэг, шувуу бүргэд таарсан бол 2023 оны судалгааны үед хар сүүлт зээр цөөн тоотой тохиолдож байв.

### 1.20.1 Хайрст амьтад (гүрвэл, могой)

Монгол орны өмнөд хэсгийн говь цөлд хатуу ширүүн улирлын нөхцөл болон хуурай ба хагас хуурай нөхцөлд дасан зохицсон хэдэн зүйлийн өргөн тархацтай гүрвэл болон могойны зүйлүүд тархсан байдаг. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт өнөөг хүртэл хийсэн судалгаанд найман зүйлийн гүрвэл болон таван зүйлийн могой байдаг хэмээн тэмдэглэгдсэн байна. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гүрвэл болон могойны зүйлүүдийн аль нь ч ОУБХХ-ны ангиллаар дэлхийн хэмжээнд ховордсон ангилалд буюу улсын хэмжээнд Монгол орны хэвлээр явагч болон хоёр нутагтны Улаан дансанд (Тэрбиш ба бусад, 2006) ховордсон хэмээх ангилалд багтаагүй байна. Ерөнхийдөө, Өмнөговь дахь гүрвэл болон могойн зүйлүүд тус бүсэд явагдаж буй янз бүрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны нөлөөгөөр ховордох аюул бага байна.



Хонин гүрвэл (*Phrynocephalus cf. przewalskii*)



Говийн гүрвэл (*Eremias przewalskii*)



Нарийн могой (*Coluber spinalis*)



Хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*)

**Зураг 98. Тус бүс нутагт тархсан мөлхөгчдийн фото зураг**

**Хүснэгт 29. Тус бүс нутагт тархсан мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүн**


№	Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	IUCN Red List (2006) Global category	Монгол улсын улаан ном 2013	CITES I,II хавсралт	Улаан данс (2006)
1	Монгол бах	<i>Bufo raddei</i>	YX			АӨ
2	Толбот хонин гүрвэл	<i>Phrynocephalus versicolor</i>	YX	-	-	АӨ
3	Төмөр гүрвэл	<i>Alsophylax pipiens</i>	YX			АӨ
4	Нохой гүрвэл	<i>Teratoscincus przewalskii</i>	YX			ХБ
5	Замба гүрвэл	<i>Laudakia stoliczkana</i>	YX			ХБ
6	Загалт гүрвэл	<i>Eremias vermiculata</i>	YX			АӨ
7	Могой гүрвэл	<i>Eremias multiocellata</i>	YX	-	-	АӨ
8	Говийн гүрвэл	<i>Eremias przewalskii</i>	YX			АӨ
9	Монгол гүрвэл	<i>Eremias argus</i>	YX			АӨ
10	Сум могой	<i>Psammophis lineolatus</i>	YX			АӨ
11	Рашааны могой	<i>Elaphe dione</i>	YX	-	-	АӨ
12	Бамбай хоншоорт	<i>Aqkistrodon halys</i>	YX	-	-	АӨ

**Тайлбар:** АӨ-анхааралд өртөхөөрөгүй; ХБ-ховордож болзошгүй; YX-үнэлгээ хийгдээгүй;

**Монгол гүрвэл (*Eremias argus*)**

Жинхэнэ гүрвэлийн овог (*Lacertidae*) бөгөөд Монголд *E. barbouri*, *E. argus* гэсэн хоёр салбар зүйл тархсан хэмээн үздэг.

**Хүснэгт 30. Монгол гүрвэлийн талаарх үндсэн мэдээлэл**

Үзүүлэлт	Тайлбар
Бүс нутгийн тархац	Монгол дахь тархан амьдрах нутаг нь 767,569 км <sup>2</sup> . Монгол гүрвэл өргөн уудам тархацтай, тоо толгой элбэг амьтан тул хээрийн бүсийн хэв шинжийг илэрхийлэгч нэг индикатор болдог.  Монгол дахь тархац
Олон улсын үнэлгээ	Үнэлгээ хийгдээгүй

Бүс нутгийн үнэлгээ	Анхааралд өртөхөөргүй
Үнэлгээний үндэслэл	Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл (Ананьева нар, 1998; Terbish нар, 2006). Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.
Хамгаалсан байдал	Монгол гүрвэлийн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.
Ховордлын гол шалтгаан	Биотопын зүйл учир уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын хөрс эвдэрсэнээс болж тархац нутагт тоо толгой хомсдох магадлалтай.
Эх сурвалж: Х.Тэрбиш., Х.Мөнхбаяр., Е.Л.Clark., Ж.Мөнхбат., Е.М.Monks., М.Мөнхбаатар., J.E.M.Baillie., Н.Батсайхан., Л.Я.Боркин., Р.Самъяа., Д.В.Семенов. (Эмхэтгэгчид, редакторууд) (2006). Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.	

### **Бамбай хоншоорт (*Gloydus halys*)**

Жинхэнэ гүрвэлийн овог (*Lacertidae*) бөгөөд Монголд *E.barbouri*, *E. argus* гэсэн хоёр салбар зүйл тархсан хэмээн үздэг.

#### **Хүснэгт 31. Бамбай хоншоорт могойны талаарх үндсэн мэдээлэл**

Үзүүлэлт	Тайлбар
Бүс нутгийн тархац	Монгол дахь тархан амьдрах нутаг нь 767,569 км <sup>2</sup> . Монгол гүрвэл өргөн уудам тархацтай, тоо толгой элбэг амьтан тул хээрийн бүсийн хэв шинжийг илэрхийлэгч нэг индикатор болдог.  Монгол дахь тархац
Олон улсын үнэлгээ	Үнэлгээ хийгдээгүй
Бүс нутгийн үнэлгээ	Анхааралд өртөхөөргүй

Үнэлгээний үндэслэл	Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл (Ананьева нар, 1998; Terbish нар, 2006). Популяцийн тоо хэмжээ буураагүй гэж үнэлэгдсэн.
Хамгаалсан байдал	Монгол гүрвэлийн тархац нутгийн 8 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.
Ховордлын гол шалтгаан	Биотопын зүйл учир уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын хөрс эвдэрсэнээс болж тархац нутагт тоо толгой хомсдох магадлалтай.
Эх сурвалж: Х.Тэрбиш., Х.Мөнхбаяр., Е.Л.Clark., Ж.Мөнхбат., Е.М.Monks., М.Мөнхбаатар., J.E.M.Baillie., Н.Батсайхан., Л.Я.Боркин., Р.Самъяа., Д.В.Семенов. (Эмхэтгэгчид, редакторууд) (2006). Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.	

### 1.20.2 Шувуу



**Зураг 99. Хээрийн судалгааны үед тааралдсан шувууд**

Судалгаа болон өмнөх судлаачдын тэмдэглэснээр тус бүс нутаг дэвсгэрт 8 багт хамаарах 38 зүйлийн шувууд бүртгэгдсэн ба эдгээр зүйлүүдийн амьдралын хэлбэр, монгол орны улаан номонд орсон эсэх CITES-ийн конвенцийн заалтад хэрхэн туссан зэргийг дараах хүснэгтэд харуулав.

#### **Хүснэгт 32. Шувуудын оршин амьдрах хэлбэр, хамгаалал**

№	Монгол нэр	Латин нэр	Орших хэлбэр	МУ-ын Улаан ном	CITES
<b>ШОНХОПТОН - Falconiformes</b>					
1	Сохор элээ	<i>Milvus migrans</i>	НӨ		II
2	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>	С		II
3	Таравжи бүргэд	<i>Aquila nipalensis</i>	НӨ		II
4	Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>	С		II
5	Ооч ёл	<i>Gypaetus barbatus</i>	С	X	II
6	Нөмрөг тас	<i>Aegypius monachus</i>	С		II
7	Хималайн хажир	<i>Gyps himalayensis</i>	НӨ	X	II
8	Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	НӨ		II
9	Шууман шонхор	<i>Falco subbuteo</i>	НӨ		II
10	Начин шонхор	<i>Falco tinnunculus</i>	НӨ		II
<b>ТАХИАТАН - Galliformes</b>					
11	Эрээн хавирга хахилаг	<i>Alectoris chukar</i>	С		
12	Дагуур ятуу	<i>Perdix dauuricae</i>	С		
	ТОГОРУУТАН	GRUIFORMES			
13	Өвөгт тогируу	<i>Anthropoides virgo</i>	НӨ		II
14	Хонинтоодог	<i>Otis tarda</i>	НӨ	X	II
15	Жороо тоодгой	<i>Chlamydotis undulata</i>	НӨ	X	I
<b>ХИАЗТАН - CHARADRIIFORMES</b>					
16	Нарийн хиазат	<i>Charadrius dubius</i>	НӨ		
17	Умардын хавтгаалж	<i>Vanellus vanellus</i>	НӨ		
18	Мөнгөлөг цахлай	<i>Larus argentatus</i>	НӨ		
<b>ТАГТААТАН - COLUMBIFORMES</b>					
19	Монгол ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>	С		
20	Буулгат хүүрзгэнэ	<i>Streptopelia decaocto</i>	НӨ		
<b>УУЛЬТАН - STRIGIFORMES</b>					
21	Эгэл шаршувуу	<i>Bubo bubo</i>	С		II
22	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>	С		II
<b>УРААЦАЙТАН - APODIFORMES</b>					
23	Хондлойцагаан ураацай	<i>Apus pacificus</i>	НӨ		
24	Бөвөөлжин өвөөлж	<i>Upupa epops</i>	НӨ		
<b>БОРШУВУУТАН - PASSERIFORMES</b>					
25	Талын жиргэмэл	<i>Calandrella cinerea</i>	НӨ		
26	Дэрсний жиргэмэл	<i>Calandrella cheleensis</i>	НӨ		
27	Шоорон эвэртболжмор	<i>Eremophila alpestris</i>	С		
28	Шар цэгцгий	<i>Motacilla flava</i>	НӨ		
29	Хөх цэгцгий	<i>Motacilla alba</i>	НӨ		
30	Үнсэн дунхай	<i>Lanius excubitor</i>	НӨ		
31	Хон хэрээ	<i>Corvus corax</i>	С		
32	Монгол хуланжороо	<i>Podoces hendersoni</i>	С	X	
33	Бүжимч чогчиг	<i>Oenanthe isabellina</i>	НӨ		
34	Цөлийн чогчиг	<i>Oenanthe deserti</i>	НӨ		
35	Хадны жижир	<i>Monticola saxatilis</i>	НӨ		
36	Оронгийн боршувуу	<i>Passer domesticus</i>	С		
37	Хадны боршуу	<i>Petronia petronia</i>	С		
38	Монгол божирог	<i>Pyrgilauda davidiana</i>	С		
	<b>Нийт</b>			<b>5</b>	<b>15</b>

Тайлбар: НӨ - Нүүдлийн өндөглөдөг-23; С – Суурин-15; Нийт-38

Шувуудыг амьдралын хэлбэр нь голчлон хээржсэн цөлд амьдрах бөгөөд гандуу нутгийн жижиг уул, толгодод амьдардаг шувуудын бүрдэл юм. Энэ нутагт жилийн турш байнга амьдардаг ойр зуур бага зэрэг нүүдэл хийх боловч суурин амьдардаг 15 зүйл шувуу байдаг. Эдгээрээс 2 зүйл Монгол улсын улаан номонд данстай, 6 зүйл шувуу CITES- ийн конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн. Манай оронд хавар 3-р сарын дунд үеэс ирээд, өндөглөн зусаад, намар 10- сарын сүүлч болоход буцдаг (нүүдлийн, өндөглөдөг) 23 зүйл шувуу тэмдэглэгдсэн байна. Дээрх шувуудаас 3 зүйл монгол улсын улаан номонд данстай, 8 зүйл шувуу CITES- ийн конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн. Жороо тоодгой (*Chlamydotis undulate*) гэх нэг зүйл шувуу Азийн болон Монгол улсын улаан номонд данслагдсан.

### **1.20.3 Тал хээрийн түүрайтан буюу хөхтөн**

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр нь жижиг хөхтөн (жишээлбэл, алагдаахай, чичүүл, багваахай, зараа), махчин амьтад (жишээлбэл, суусар, зэрлэг муур, үнэг, чоно) болон Өмнөговийн бүс нутагт нийтлэг тохиолддог томоохон өвсөн тэжээлтэн амьтдаар баян юм. Энэхүү бүс нь хулан - *Equus hemionus* болон хар сүүлт зээр - *Gazella subgutturosa* зэрэг түүхэн тархац нутгийнхаа ихэнхи хэсэгт устаж үгүй болсон дэлхийн хэмжээнд чухал популяцуудын гол амьдрах нутаг болж байна. Хад чулуу, уулархаг бүс нь янгир - *Capra sibirica* болон аргалийн - *Ovis ammon* амьдрах нутаг болж байдаг.

Тус бүс нутагт нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай зүйл амьтан бол хулан юм. Энэ зүйлийн ОУБХХ болон Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд (Кларк, ба бусад. 2006) устаж болзошгүй хэмээх ангилалд багтаасан. Өмнөговийн бүсэд хулангийн дэлхийн хэмжээнд чухал популяцуудын талаар сайн судлагдсан боловч энэхүү нүүдлийн зүйл амьтны амьдрах орчин нь зам тээвэр дэд бүтэц, уул уурхай н томоохон төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр хумигдсаар байгаа.



**Зураг 100. Цагаан зээр - *Procapra gutturosa***



### Хүснэгт 33. Тус нутаг дэвсгэрт тохиолдох хөхтний зүйлийн бүрдэл, хамгаалал

	Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	IUCN Red List (2006) Global category	Монгол Улсын ховор амьтны жагсаалт 2012	Монгол улсын Улаан ном, 1987,1997,2013	CITES I, II хавсралт	Улаан данс (2006)	Амьтны тухай хууль 2012	Агнуурын ач холбогдолтой
Туруутан - artiodactyla									
1	Хар сүүлтий	<i>Gazella subgutturosa</i>	ЭМ	+	+		ЭМ		+
2	Аргаль хонь	<i>Ovis ammon</i>	ЭМ	+	+	II	УБ		+
3	Янгир ямаа	<i>Capra sibirica</i>	АӨ	+	+		ХБ		+
4	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	АӨ	-	-		ХБ		+
Туурайтан – perissodactyla									
5	Хулан адуу	<i>Equus hemionus</i>	ЭМ	+	+	I	УБ		+
Махчтан – carnivora									
6	Говийн шүлүүс мий	<i>Lynx lynx isabellina</i>	ХБ	+	+	II	ХБ		+
7	Мануул мий	<i>Otocolobus manul</i>	ХБ			II	ХБ		+
8	Саарал чоно	<i>Canis lupus</i>	АӨ			II	ХБ		+
9	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	АӨ			-	ХБ		+
Туулайтан – lagomorpha									
10	Бор туулай	<i>Lepus tolai</i>	АӨ	-	-	-	АӨ		+
11	Үхэр огдой	<i>Ochotona pallasii</i>	АӨ	-	-	-	АӨ		
Зараатан – erinacei									
12	Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>	АӨ	-	-	-	АӨ		
Далавчтан – chiroptera									
13	Говийн сармаахай	<i>Eptesicus gobiensis</i>	АӨ				АӨ		
14	Борхон турсаахай	<i>Hypsugo savii</i>	АӨ				МД		
15	Сахалт багваахай	<i>Myotis mystacinus</i>	АӨ				АӨ		
16	Том соотон багваахай	<i>Plecotus austriacus</i>	АӨ				МД		
17	Буурал сармаахай	<i>Vespertilio murinus</i>	АӨ				АӨ		
Мэрэгчтэн – rodentia									
18	Сибирь алагдаага	<i>Allactaga sibirica</i>	АӨ	-	-	-	АӨ		
19	Говийн алагдаага	<i>Allactaga bullata</i>	ХБ				МД		
20	Хадны барагчин	<i>Alticola semicanus</i>	АӨ				АӨ		
21	Таван-хуруут атигдаахай	<i>Cardiocranius paradoxus</i>	ЭМ	-		-	МД		
22	Элсний зусаг	<i>Phodopus roborovskii</i>	АӨ				АӨ		
23	Цомч шижүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>	АӨ				АӨ		

24	Өөхөн-сүүлт атигдаахай	<i>Salpingotus crassicauda</i>	ЭМ				МД		
25	Элсч савагдаахай	<i>Dipus sagitta</i>	АӨ				АӨ		
26	Монголжин даахай	<i>Stylodipus andrewsi</i>	АӨ				АӨ		
27	Бүрдэн шишүүхэй	<i>Cricetulus sokolovi</i>	АӨ				МД		
28	Элсний зусаг	<i>Phodopus roborovskii</i>	АӨ	-	-	-	АӨ		
29	Түвд ов	<i>Eolagurus przewalskii</i>	АӨ				МД		
30	Шаргал чичүүл	<i>Merionus meridianu</i>	АӨ	-	-	-	АӨ		
				5	5	5			9

**Тайлбар:** АӨ – анхааралд өртхөөргүй; МД – мэдээлэл дутмаг; УБ- устаж болзошгүй, ХБ- ховордож болзошгүй, ЭМ – эмзэг, + -агнуурын ач холбогдолтой;

Хээрийн судалгаа болон урд өмнө хийсэн судалгаа, ном бүтээлээс магадлахад төслийн бүс нутаг орчимд 7 багийн 30 зүйлийн хөхтөн амьтад байршин нутагладаг байна.




**Зураг 101. Хөхтөн амьтдын зүйлийг бүрдэл**

Дээрх хүснэгтээс харахад тухайн төслийн талбай орчимд Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор ховор амьтны жагсаалтад орсон 5 зүйл, Монгол улсын улаан номонд орсон 5 зүйл ховор амьтад байна. Амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын I хавсралтад (хулан адуу), II хавсралтад орсон (аргаль хонь, шилүүс мий, мануул мий, саарал чоно) 5 зүйл байгаа нь төслийн үйл ажиллагааны үед хууль бус агнууртай тэмцэх, сурталчилгаа хийхэд анхаарах шаардлагатай болно. Энд дурдсан хулан адуу нь энэ нутагт 10-аад жилийн өмнө хэвийн байршин нутаглаж байсан боловч уул


уурхайн нөлөөгөөр Монгол орны тархац нутаг нь энэ хэсгээр тасархайтан маш ховордсон.

Агнуурын ач холбогдолтой 9 зүйл байна. Үүнээс 5 зүйл нь ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд Төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр агнадаг. Үлдсэн 5 зүйл амьтныг амьтны тухай хуульд заасан хугацаанд агнах боломжтой байдаг. Төслийн бүс нутагт талбай дахь хөхтөн амьтдаас олон улсын үнэлгээгээр устаж болзошгүй 1 зүйл, ховордож болзошгүй 5 зүйл, эмзэг зэрэглэлд 5 зүйл, анхааралд өртөхөөргүй 18 зүйл байна.



**Зураг 102. Олон улсын үнэлгээ (IUCN Red List 2006)**

Бүс нутгийн үнэлгээ буюу Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд үнэлэгдсэн байдлыг авч үзвэл устаж болзошгүй 2 зүйл, ховордож болзошгүй 6 зүйл, эмзэг 2 зүйл, анхааралд өртөхөөргүй 12 зүйл, мэдээлэл дутмаг 8 зүйл байна. Гэхдээ энэ мэдээлэл дутмаг гэдэг үнэлгээ нь говийн алагдаага, козловын атигдаахай, өөхөнсүүлт атигдаахай зэрэг ховор амьтдын үнэлгээг тодорхойгүй болгосон.




**Зураг 103. Монгол орны хөхтөн амьтны улаан дансны үнэлгээ**

Төслийн үйл ажиллагааны үед нөлөөлөлд өртөж ховордож, устаж болзошгүй зарим зүйл амьтдын тархац нутаг, тоо толгойн ховордлын шалтгаан, хамгааллын статус бүхий мэдээллийг доор товч танилцуулав.

Хар сүүлтий (*Gazella subgutturosa*): Монгол орны хар сүүлтий нь Дэлхийн хар сүүлтийн тархац нутгийн хамгийн хойд, зүүн хойд, зүүн зах нь болдгоороо онцлогтой. Энэ зүйлийг олон улсын үнэлгээгээр эмзэг (ЭМ), А2ad, бүс нутгийн үнэлгээ эмзэг (ЭМ), А3cde гэсэн зэрэглэлд оруулсан. Нэлээд удам тархацтай боловч хэсэг хэсэг нутагт тасархайтан хумигдаж тоо толгой, нягтшил нь багассаар байгаа.


Засгийн газрын 7-р тогтоолоор (2012 он) ховор амьтны жагсаалтад оруулсан. Монгол улсын улаан номын гурван удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр тус тус бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; Шийрэвдамба нар, 2013). Хар сүүлтийн тархац нутгийн 15 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.



Зураг 104. Хар сүүлтийн тархац нутаг, нягтшил

Монгол орны хар сүүлтийн үндсэн популяц Өмнөговийн баруун хэсэг, Говийн бага дархан газарт, Галбийн говь байх бөгөөд дэлхэц нутгийн бусад хэсэгт хар сүүлийн байршил сарнисан, сийрэг нягтшилтай байдаг.


**Цагаан зээр (*Procapra guturosa*):** Энэ зүйл олон улсын үнэлгээгээр анхааралд өртөхөөргүй (АӨ), бүс нутгийн үнэлгээ нь ховордож болзошгүй (ХБ) гэсэн байдаг. Цагаан зээрийн тархац байршилд байгаль цаг уур, бэлчээрийн байдал, өвчин эмгэг, дэд бүтцийн хөгжил, эрчимтэй агнуур голлон нөлөөлсөөр иржээ.



**Зураг 105. Цагаан зээрийн тархац нутаг, нягтшил**

*Хулан адуу (Equus hemionus)*: Энэ зүйлийн олон улсын үнэлгээ нь эмзэг (ЭМ) зэрэглэлтэй бөгөөд бүс нутгийн үнэлгээ нь устаж болзошгүй (УБ) гэсэн статустай. Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн I хавсралтад бүртгэсэн. Засгийн газрын тогтоолоор (2012 оны №7) ховор амьтны жагсаалтад оруулсан. Монгол улсын улаан номын гурван удаагийн хэвлэлд ховор зэрэглэлээр орсон байна.

Монгол орны хулан адуу нь Дэлхийн хулан адууны хамгийн том популяц гэдгээрээ Олон улсын анхаарлын төвд байдаг. Хулан адуу нь төсөл хэрэгжих энэ нутагт уул уурхайн нөлөөгөөр Өмнөговь аймгийн баруун хэсэгт тоо толгой цөөрч, тархац нутаг тасархайтан маш ховордсон байна.



Зураг 106. Хулан адууны тархац нутаг, нягтшил

Монгол орны хулан адууны гол байршил нь Говийн их дархан цаазат газар, Говийн бага дархан газарт байна.

Хүснэгт 34. Төсөл хэрэгжих нутаг дах нэн чухал биологийн төрөл зүйлүүд

Ангилал зүйн нэгж	Биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсэг	Шинжлэх ухааны нэр	ОУБХХ-ны Улаан дансны статус	Монгол Улсын улаан дансны статус	Судалгааны нэгж хэсэг дэх байдал
Хөхтөн (туурайтан амьтан)	Хулан	<i>Equus hemionus</i>	Устаж болзошгүй (EN)	Устаж болзошгүй (EN)	Нүүдлийн “суурин”
Хөхтөн (туурайтан амьтан)	Аргаль	<i>Ovis ammon</i>	Ховор дож болзошгүй (NT)	Устаж болзошгүй (EN)	Нутагшсан “суурин”
Хөхтөн (туурайтан амьтан)	Хар сүүлт зээр	<i>Gazella subgutturosa</i>	Эмзэг (VU)	Эмзэг (VU)	Нүүдлийн “суурин”
Хөхтөн (туурайтан амьтан)	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	Анхаа ралд өртөхөөргүй (LC)	Устаж болзошгүй (EN)	Дорно зүгээс ховорхойн ирдэг зүйл
